

ОЛОН УЛСЫН РОТАРИЙН 3450 ДҮҮРЭГ - 9, 10 БҮС

2023 - 2024 РОТАРИ ЖИЛИЙН ТАЙЛАН

ОЛОН УЛСЫН РОТАРИЙН 3450 ДҮҮРГИЙН

Б.Сальма

9-гээр Бүсийн Захирагч

Б.Номуунбилэгт

10-гаар Бүсийн Захирагч



ОЛОН УЛСЫН РОТАРИЙН 2023 – 2024 ОНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ ГОРДОН МАКЛНАЛЛИГИЙН МЭНДЧИЛГЭЭ

ГОРДОН МКЛНАЛЛИЙН:

МИНИЙ СЭТГЭЛД ХОНОГШСОН
ХАМГИЙН ЧУХАЛ НЭГ ЗҮЙЛ БОЛ
МОНГОЛЫН РОТАРИЧУУДЫН
РОТАРИЙН ТӨЛӨӨ ГЭСЭН
БАХАРХАЛ, ХҮСЭЛ ТЭМҮҮЛЭЛ,
БҮТЭЭЛЧ БАЙДАЛ БАЙЛАА.

**Ямар гайхамшигтай Ротари жил болж байна
вэ.**

Бид илүү их хөгжиж, илүү ихийг хийж
сорилт бүрийг даван туулсанаар Ротари нь
олон жилийн турш өргөн хүрээнд тал бүрээр
өсөн дэвшиж байна.

Бид энэ жил НҮБ-ын Хүүхдийн сан,
Хамтын нөхөрлөлийн орнууд болон дэлхийн
удирдагчидтай өндөр түвшинд уулзаж чухал
ажлуудыг амжуулж, асуудал дагуулсан салбар
бүрт хүрэхийг зорьж нийгмийн өөрчлөлтийн
шинэ шинэ төслүүдийг хэрэгжүүлж байна.

Бидний санаа тавьсан, хүчин чармайлт
гаргасан боломжууд нь охидыг чадавхжуулах,
хүрээлэн буй орчноо сайжруулах, бичиг
үсгийн боловсрол олгох, эрүүл мэндийг
сайжруулахад чиглэж шинэ боломжуудыг
нээж өгч байна.

Миний бие Ротари байгууллагын
Ерөнхийлөгч хүний хувиар Монгол оронд
айлчилж Монголын Ротаричууд, гишүүдэд
амласан амлалтаа биелүүлэх сайхан завшаан
тохиосон.



Айлчлалынхаа үеэр бидний анхаарлаа
хандуулж байдаг хэд хэдэн чиглэлийг хөндсөн
олон төсөл, хөтөлбөрүүдтэй танилцаж, Монгол
Улсын Их Хурлын Даргатай биечлэн уулзаж,
харилцан сонирхсон салбаруудыг цааш судлах,
Монголын Үндэсний Телевизээр өөрсдийн
тухай ярилцлага өгөх зэрэг олон зүйлийг
амжуулсан.

Миний сэтгэлд хоногшсон хамгийн
чухал нэг зүйл бол Монголын Ротаричуудын
Ротарийн төлөө гэсэн бахархал, хүсэл тэмүүлэл,
бүтээлч байдал байлаа.

Та бүхэн бол дэлхийд итгэл найдварыг бий
болгоход тусалдаг, жинхэнэ баатрууд шүү - энэ
бүхэн надад маш их урам зориг өгсөн.

Ротаричууд - Та бүхэнд маш их
баярлалаа гэж хэлмээр байна. Мөн бид элэг нэгт
хүмүүсийнхээ төлөө санаа тавьж, зүрх сэтгэлдээ
амар амгаланг бий болгож чадна гэдгийг батлан
харуулсан Ротарийн Олон улс, Зон, Дүүрэг,
Бүсийн түвшинд ажиллаж буй танай гайхалтай
хамт олонд талархал илэрхийлье.

Гордон Маклналли
Олон Улсын Ротарийн Ерөнхийлөгч, 2023-24

ОЛОН УЛСЫН РОТАРИЙН 2023 – 24 ОНЫ 3450 ДҮҮРГИЙН ЗАХИРАГЧ АНДИ ЛИГИЙН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт Ротаричууд, Ротарактууд, Интеракторууд, Залуучууд, Найзууд аа,

“Дэлхийд итгэл найдварыг бүтээе” уриатай 2023-24 оны Ротарийн жилийн турш гайхалтай амжилтуудыг гаргаж ажилласан Монголын Ротари Клубүүддээ баяр хүргэе.

Энэ жил шинээр 4 Ротари клуб: Шинэ Гүүр, Хүннү, Мөрөн Хүрээ, Хангай болон Монголын анхны Жуниоракт клубууд үүсгэн байгуулагдсаныг тэмдэглэхэд таатай байна.

Уламжлал болсон Халдварт Саа Өвчинтэй тэмцэх АЛХАЛТ болон Ротари өдөр -ийг зохион байгуулсан нь Монголын олон нийтийн дунд Ротари байгууллагын нэр хүндийг нэмэгдүүлэхэд чухал арга хэмжээнүүд болжээ.

Миний бие, Дүүргийн Захирагчийн хувиар албан ёсны айлчлалаар 8-р сард, мөн Олон Улсын Ротарийн Ерөнхийлөгч Гордон Макиналли, хатагтай Хитер Макиналли нарын 11-р сард Монголд хийсэн айлчлалд оролцон 2023-24 оны Ротарийн жилд Монгол улсад 2 удаа айлчлах завшаантай хэрэг тохиосонд баяртай байна.

Энэхүү айлчлал бүрт намайг элгэмсэг, халуун дотноор хүлээн авч байсанд та бүхэнд чин сэтгэлээсээ талархал илэрхийлье. Улсын 1-р эмнэлгийн лазер төхөөрөмжийн төсөл, Ger for Life, Horse for Life, Сургуулийн ариун цэврийн байгууламж сайжруулах зэрэг Монгол Улсад хэрэгжиж буй олон гайхалтай төслүүдийн гэрч болсондоо таатай байна. Мөн эдгээр гайхалтай

төслүүдийг санаачилсан Монгол дахь Ротарактуудын хүчин чармайлтыг би онцгойлон үнэлмээр байна.

Олон Улсын Ротарийн Ерөнхийлөгч Гордон Макиналли Ротарактуудын оруулсан хувь нэмрийг гүнээ хүндэтгэн, талархан хүлээн авч байлаа. Цаашлаад Сингапур улсад зохион байгуулагдсан Олон Улсын Ротари Конвенцид Монгол улсаас гуч гаруй Ротари болон Ротаракторууд оролцсон нь бидний олон улсын түвшний нөхөрлөл, хамтын ажиллагааг бэхжүүлсэн үйл явдал боллоо.

Ирэх жил Ази Номхон Далайн Бүсийн Ротарактуудын Чуулганыг Монгол улсад зохион байгуулах сорилтыг хүлээсэн Монголын Ротаракторууддаа талархал илэрхийлье. Та бүхэндээ энэхүү бүс нутгийн Ротаракт арга хэмжээг зохион байгуулах ажилд тань амжилт хүсье. Мөн Монголын Ротари албан тушаалтнууд болох Бүсийн Захирагч Сальма, Бүсийн Захирагч Номуунбилэгт, Бүсийн Дэд Захирагч Жавхлан, Бүсийн Дэд Захирагч Доко, Дүүргийн Дэд Нарийн Бичгийн Дарга Намжилмаа, Ротари Мэдээллийн Төвийн менежер Бүсийн Захирагч Асан Бэрээ нартаа үнэтэй хувь нэмэр оруулсанд нь чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлэхийг хүсэж байна.

Дүүргийн Албан Тушаалтнуудын Сургалт, Сонгогдох Ерөнхийлөгчдийн Сургалт Семинар, Үүсгэн байгуулагч Ерөнхийлөгчийн Академи болон шинэ гишүүдэд зориулсан сургалт зэрэг Дүүргийн сургалтуудыг Монгол улсад удирдан явуулсан Бүсийн Захирагч Асан Мийгаадаа баярлалаа. Мөн намайг Дүүргийн захирагчаар ажиллах хугацаанд тууштай дэмжлэг үзүүлж, удирдан чиглүүлж байсан Бүсийн Захирагчдын Зөвлөлд талархлаа илэрхийлж байна. Эцэст нь, Бүсийн Захирагч Сальма -д манлайлал, хичээл зүтгэлээрээ үнэлэгдэн, Монголын ОНЫ ШИЛДЭГ” Ротарийн гишүүн болсонд баяр хүргэе.

Бид Монгол дахь Ротари хөгжлийн шинэ хуудсыг эхлүүлж байгаа энэ үед ирэх жилийн Бүсийн Захирагчид болох Жавхлан, Доко нартаа чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж байна. “Ротарийн ид шид” уриа бүхий 2024-25 оны Ротари жилийн Дүүргийн Захирагч Найжел Логийн удирдлага, манлайлал дор Та бүхэн Ротарийн эрхэм зорилгыг бэхжүүлэхэд чухал ахиц дэвшил гаргана гэдэгт итгэлтэй байна. Та бүхний гайхалтай хүсэл зориг, хичээл зүтгэлд тань дахин талархлаа илэрхийлье.



Анди Ли
Дүүргийн Захирагч (2023-2024)
Олон улсын Ротарийн 3450 Дүүрэг

РОТАРИЧУУД ХАМТДАА ИТГЭЛ НАЙДВАРЫГ БҮТЭЭЖ ЧАДСАН НЭГЭН ГАЙХАМШИГТАЙ ЖИЛИЙГ ҮДЭЖ БАЙНА.

Эрхэм хүндэт Ротаричууд, Ротарактууд, Интерактууд болон Ротарийг дэмжигчид, гэр бүл, анд найз нар та бүхэндээ Ротарийн Жилийн мэнд хүргэе.

2023-24 оны Ротарийн жилд Монголын 9,10-р Бүсийн харьяанд нийт 22 Ротари клуб, 14 Ротаракт клуб, 21 Интеракт, 1 Жуниоракт клуб, тэдгээрийн 1,500 гаруй гишүүд хамт олон үйл ажиллагаагаа амжилттай явуулж ирлээ.



ОУР-ын Ерөнхийлөгч Эрхэм болон Дүүргийн Захирагчийн албан айлчлалын хүрээнд олон нэр хүндтэй зочдыг эх орондоо өндөр хэмжээнд хүлээн авч, гишүүд дэмжигчдийнхээ зүрх сэтгэл нь шингэсэн нийгмийн сайн сайханд чиглэсэн онцгой сайхан төслүүдээ танилцуулж, урамтай сэтгэгдлийг нь сонсож, дэлхийн нэр хүндтэй байгууллагын үнэ цэнтэй гишүүд, хамт олон гэдгээрээ бахархах торгон мөч бүхэн маш гайхалтай байлаа.



2023-24 оны Ротарийн жилд бид НҮБ-ын Залуучуудын газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах нийгэмлэг, Монгол-Францын төв, Азийн Сан, Каритас Чех Репаблик, АНУ-ын Энх тайвны корпус зэрэг нийгмийн сайн сайхны төлөө санаа зорилго нэгт олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтран сайн түншлэлийн хүрээнд хамтын ажиллагаагаа улам өргөжүүлсэн жил байлаа.

ОУ Ротарийн 119 жилийн, Монголын Ротари хөдөлгөөний 29 жилийн энэ бүх хугацаанд дэлхий дахинаа нийгмийн өмнө тулгамдаж буй олон асуудлуудад шийдэл гаргах, бусдад туслах, илүү сайн сайхан нийгмийг бүтээх их үйлсийг Ротари, Ротаракт, Интеракт, Жуниоракт клубын та нар, та бүхэн шиг ГИШҮҮН бүр гар бие оролцож, бүтээж, санаачилж, хэрэгжүүлж байгаа шүү гэдгийг бахархалтайгаар хэлмээр байна. Таны цаг, санхүү, сэтгэл, зүрх, хичээл зүтгэл бүхэн үнэ цэнтэй шүү. РОТАРИЙН ГИШҮҮН ТАНЬД БАЯРЛАЛАА.

ОУ Ротарийн 3450 Дүүргийн Монгол дахь 9-10 Бүс, Монголын Ротари хөдөлгөөний анхдагч нар, өнөөдрийн амжилтын түүчээ болсон, цаг үргэлж үлгэр жишээ үзүүлж байдаг Бүсийн Захирагч нарын Зөвлөлийн гишүүд та бүхэндээ баярлалаа.



2023-24 оны Ротарийн жил, Бүсийн түвшинд алба хашиж, хамтран ажилласан Бүсийн Менежментийн Хорооны гишүүд, албан тушаалтнууд, клубын эрхэм Ерөнхийлөгч нартаа талархал илэрхийлье.

Жилийн турш дэмжин хамтран ажилласан Ротари Мэдээллийн Төвд талархал илэрхийлэхийг хүсч байна. Мөн Монголын Ротари хөдөлгөөний үйл ажиллагааг дэмжин тусалдаг Ротари Хөгжлийн Санд баярлалаа.

2024-2025 оны Ротарийн жилд 9,10-р Бүсийн Захирагчаар ажиллахаар сонгогдсон Б. Долгосүрэн болон Б. Жавхлан нартаа, тэдний удирдлагын багт их амжилтыг хүсч, дахин нэг гайхалтай жилийг хамтдаа бүтээцгээе.

Бүсийн Захирагч нарын хувиар Ротарийн гэр бүлийнхээ гишүүн бүрт нийгмийн төлөө хийж буй эрхэм нэр хүндтэй сайн үйлсэд нь улам их амжилт хүсье.

Монголын Ротаричууд улам олуулаа болж, хамтдаа их зүйл бүтээхийг хүсэн ерөөе!

**Хүндэтгэсэн,
Болор-Эрдэнийн Сальма, 9-р Бүсийн Захирагч
Батмөнхийн Номуунбилэгт, 10-р Бүсийн Захирагч**

АГУУЛГА

Олон Улсын Ерөнхийлөгчийн мэндчилгээ	2
ОУР 3450 Дүүргийн Захирагчийн мэндчилгээ	3
ОУР 3450 Дүүргийн 9, 10 Бүсийн захирагч нарын мэндчилгээ	4-5
Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн 2023-24 оны 9, 10-р Бүсийн Удирдлага	7
Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн 9, 10 Бүсийн 2023-2024 Ротари Жил	8-9
Монголын Ротари Хөдөлгөөний Үе, Үеийн Бүсийн Захирагч нар	10
2023 - 2024 Ротари Жилд Монголын Ротари Хөдөлгөөний үйл ажиллагаанд хандив өргөж дэмжсэн Спонсор - Ротаричууд	11
Олон Улсын Ротарийн Ерөнхийлөгчийн айлчлал	12--13
Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн Захирагчийн айлчлал	14-15
Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн 9, 10 Бүсийн Захирагч нарын айлчлал	16-17
Монгол Оронд Үүссэн Үерийн Нөхцөл Байдалд Ротаричуудын Тусламж	18-19
END POLIO алхалт	20
Ротари Спорт Өдрүүд	21
Ротари Шинэ Жил	22
Ротари Өдөр Монголд	23
Ротари Золголт	24
Интеракт 3х3 Сагсан Бөмбөгийн Тэмцээн	25
Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн Конференци	26
Олон Улсын Ротарийн Чуулга	27
Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн 9, 10 Бүсийн Сургалтын Хороо	28
Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн 9, 10 Бүсийн Гишүүнчлэлийн хороо	29
Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн 9, 10 Бүсийн Залуучуудын хороо	30-31
Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн 9, 10 Бүсийн Сангийн хороо	32
Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн 9, 10 Бүсийн Эрүүл Мэндийн хороо	33
Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн 9, 10 Бүсийн Виртуал Сургалт, Солилцооны хороо болон Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн 9, 10 Бүсийн Олон Талт, Эрх тэгш, Хүртээмжтэй байдлын хороо	34
Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн 9, 10 Бүсийн Байгал Орчны хороо	35
Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн 9-р Бүсийн Ротари Клубууд	36-47
Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн 10-р Бүсийн Ротари Клубууд	48-59
Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн 9,10-р Бүсийн Ротаракт Клубууд	60-72
Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн 9,10-р Бүсийн Интеракт Клубууд	73-83
Ази Номхон Далайн Бүсийн Ротарактуудын (APRRC) 2025	84
Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн 9,10 Бүсийн 2024-2025 Ротари Жил	85

**ОЛОН УЛСЫН РОТАРИЙН 3450 ДҮҮРГИЙН
9 БОЛОН 10-Р БҮСИЙН 2023 – 2024 ОНЫ УДИРДЛАГЫН БАГ**



DG АНДИ ЛИ
Олон Улсын Ротарийн
3450 Дүүргийн Захирагч



DS АЛЕКСАНДР ЧЕНГ
Олон Улсын Ротарийн
3450 Дүүргийн Монголыг
хариуцсан нарийн бичгийн дарга



AG Б. САЛМА
ОУ Ротарийн 3450
Дүүргийн 9 –р Бүсийн Захирагч



AG Б. НОМУУНБИЛЭГТ
ОУ Ротарийн 3450
Дүүргийн 10 –р Бүсийн Захирагч



DAG Б. ДОЛГОРСҮРЭН
ОУ Ротарийн 3450 Дүүргийн 10 –р
Бүсийн Дэд Захирагч



DAG Б. ЖАВХЛАН
ОУ Ротарийн 3450 Дүүргийн 9 –р
Бүсийн Дэд Захирагч



DDS С. НАМЖИЛМАА
ОУ Ротарийн 3450 Дүүргийн 9, 10
Бүсийн Нарийн бичгийн дарга,
Ротариг олон нийтэд таниулах
хорооны дарга



PAG Д. БЭРЦЭЦЭГ
ОУ Ротарийн 3450 Дүүргийн 9, 10
Бүсийн Эрүүл Мэндийн хорооны
дэд дарга, Ротари Мэдээллийн
Төвийн захирал



PAG Н. МЯГМАРЖАРГАЛ
ОУ Ротарийн 3450 Дүүргийн
9, 10 Бүсийн Сургалтын болон
Гишүүнчлэлийн хорооны дарга



PAG Ч. ЭНХТУЯА
ОУ Ротарийн 3450 Дүүргийн
9, 10 Бүсийн Энхтайвны хорооны
дарга



PAG Б. БУЛГАН
ОУ Ротарийн 3450 Дүүргийн 9, 10
Бүсийн Сангийн хорооны дарга



PAG Т. БОЛОРМАА
ОУ Ротарийн 3450 Дүүргийн 9, 10
Бүсийн Эрүүл Мэндийн хорооны
дарга



PAG Н. КЕРМЕН
ОУ Ротарийн 3450 Дүүргийн
9, 10 Бүсийн Виртуал Сургалт,
Солилцооны хорооны дарга



PAG Ж. ГАЛБАДРАХ
ОУ Ротарийн 3450 Дүүргийн 9, 10
Бүсийн Олон Талт, Хүртээмжтэй
байдлын хорооны дарга



PAG Д. НАРАНТУЯА
ОУ Ротарийн 3450 Дүүргийн 9,
10 Бүсийн Байгал Орчин, Ногоон
хорооны дарга



PP Х. АРИУНГОО
ОУ Ротарийн 3450 Дүүргийн 9,
10 Бүсийн Зулуучуудын хорооны
дарга



PP А. ДАШДУЛАМ
ОУ Ротарийн 3450 Дүүргийн
9, 10 Бүсийн Залуучуудын хорооны
Интеракт хариуцсан дарга



Ц. БАТ-ОРГИЛ
ОУ Ротарийн 3450 Дүүргийн 9,
10 Бүсийн Залуучуудын хорооны
Ротаракт хариуцсан дарга



Т. АЗБИЛЭГ
ОУ Ротарийн 3450 Дүүргийн
9 - р Бүсийн Ротаракт Дэд
Төлөөлөгч



Г. НОМИН
ОУ Ротарийн 3450 Дүүргийн
10-р Бүсийн Ротаракт Дэд
Төлөөлөгч

ГИШҮҮНЧЛЭЛ:

Нийт 1,500 Ротари гэр бүлийн гишүүд

4 Шинэ Ротари клуб нэмэгдэж 22 Ротари клубуудийн Гишүүдийн Нет ӨСӨЛТ Өсөлт 18% буюу 133 шинэ гишүүд.

14 Ротаракт Гишүүдийн Нет ӨСӨЛТ 25% буюу 89 шинэ гишүүд

6 Шинэ Интеракт клубууд нэмэгдэж 21 Интеракт клубуудийн Гишүүд 600 гаруй гишүүд



САН:

- 277,000 ам.долларын Ротари Санд төвлөрүүлсэн байна
- 1,000,000 орчим ам.доллар бүхий төсөл хөтөлтбөрүүдийг хэрэгжүүлж байна



СУРГАЛТ:

- Анхны CP Академи
- PETS
- Сангийн Хорооны
- Ротарийн болон бусад салбар бүрийн тусгай сургалтууд



ХУРАЛ:

- 12 Нэгдсэн Ерөнхийлөгчдийн хурал
- 6 Дүүргийн Удирдлагын хурал
- 4 Бүсийн Удирдлагын хурал
- 100+ онлайн болон биет хурлууд



АЙЛЧЛАЛ:

- ОУ Ерөнхийлөгч Гордон Макнелли болон түүний гэргий Хэйтэр
- ОУ Ротарийн 3450 Дүүргийн Захирагч Анди Ли болон түүний гэргий Жэйн
- ОУ Ротарийн 3450 удирдлага болон Хонг Конг, Макау клубуудийн Ерөнхийлөгчид болон гишүүд
- 3450 Дүүргийн 9&10-р Бүсийн захирагч нарын 22 клубуудтэй уулзсан
- Клубуудын төсөл, хамтын ажиллагааны хүрээнд ирсэн Олон Улсын зочид



РОТАРИ ЖИЛ

ХАМТЫН АЖИЛ:

- НҮБ-ын Залуучуудын газар
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах нийгэмлэг
- Монгол-Францын төв
- Азийн Сан
- Каритас Чех Репаблик
- АНУ-ын Энх тайвны корпус
- JCI байгууллага
- Үндэсний Цэцэрлэгт Хүрээлэн
- Нийслэлийн Онцгой Байдлын газар
- Клубуудийн хатран ажилдаг улсын болон хувийн хэвшлийн 100 гаруй байгууллагууд



”

АРГА ХЭМЖЭЭ:

Монголд

- ОУ Ерөнхийлөгчийн нэрэмжит хүлээн авалт
- 3450 Дүүргийн Захирагчийн Хүлээн авалт
- End Polio алхалт
- Ротари Спорт өдрүүд
- Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Нэгдсэн Экспо “Ability Expo”
- Ротари Шинэ жил
- Ротари Өдөр
- Ротари Золголт
- Дэлхийн Ротаракт 7 хоног
- 9&10 Бүсийн Итнеракт 3x3 Сагсан бөмбөгийн тэмцээн
- Ротари Цус Хандивлах Өдөр
- “Мөнхөд цохилох зүрх” Эс эд, эрхтэн шилжүүлэн суулгалтын Олон Улсын хурал
- НҮБ-ын Залуучуудын газраас зохион байгуулсан “Байгал орчны манлайлал” хөтөлбөр
- 9, 10 Бүсүүдийн Зүүсгэл Солилцох ёслол

Олон Улсад:

- 3450 Дүүргийн Итнеракт 3x3 Сагсан бөмбөгийн тэмцээн Хонг Конгт
- RYLA (Rotary Youth Leadership Awards) Хонг Конгт
- 3450 Дүүргийн Чуулга Хонг Конгт
- Олон Улсын Чуулга Сингапурт



”

ШИНЭ:

- DAGE буюу Сонгогдох Бүсийн Дэд Захирагчийн Сонгууль
- RMB буюу Rotary Means Business Бизнес Эрхлэгч Ротаричууд, Ротарактуудыг дэмжих хөтөлбөр
- Клубуудийн Сургалт, Хурал, Зүүсгэл солилцох, Ойн Баяр болон Төслийн нээлт, хаалтын арга хэмжээнүүд

ОЛОН УЛСЫН РОТАРИЙН 3450 ДҮҮРГИЙН 9 БОЛОН 10-Р БҮСИЙН ҮЕ ҮЕИЙН ЗАХИРАГЧ НАР



Ч. ГАНБОЛД
/2002-2003, 2010-2011/



Ж.Л. ГОМБО
/2003-2004/



С. БЭХБАТ
/2006-2007/



Ч. ЭНХТУЯА
/2007-2008/



Д.БЭРЦЭЦЭГ
/2009-2010/



Ч. ГАНБОЛД
/2002-2003, 2010-2011/



Л. БАЯРСАЙХАН
/2011-2012/



Г.НАМСРАЙ
/2012-2013/



С.ЖАРГАЛСАЙХАН
/2013-2014/



Э.ОЮУНГЭРЭЛ
/2014-2015/



Ц.ДЭЛГЭРЦОО
/2015-2016/



Х.ЖАМБАЛМАА
/2015-2016/



Ц.ГАНЗОРИГ
/2016-2017/



Д.НАРАНТУЯА
/2016-2017/



Н.БАЯРХҮҮ
/2017-2018/



Б.БУЛГАН
/2018-2019/



Г.ЦЭРЭНЧИМЭГ
/2018-2019/



Э.ГАНБАТ
/2019-2020/



А.МӨНХЖАРГАЛ
/2019-2020/



Д.ДАМДИНДОРЖ
/2020-2021/



Л.БАТ-ЭРДЭНЭ
/2020-2021/



Н.МЯГМАРЖАРГАЛ
/2021-2022/



Т.БОЛОРМАА
/2021-2022/



Н.КЕРМЕН
/2022-2023/



Ж.ГАЛБАДРАХ
/2022-2023/



Б.САЛЬМА
/2023-2024/



Б.НОМУУНБИЛЭГТ
/2023-2024/

Rotary
Clubs of Mongolia



CREATE HOPE
in the WORLD



РОТАРИЙНХАА ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИЖ, АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙН СПОНСОР БОЛСОН ТА БҮХЭНДЭЭ БАЯРЛАЛАА

 BB BANQUET SPONSOR 2,000,000 MNT Б. САЛЬМА Э.Р.ХУСНИН ЗАХИРАГУУ УБ БАНГАРИД РОТАРИ КЛУБ <i>Ротарийг дэмжжээ таниг баярлалаа</i> 2023-08-26 19:30 ЦАГТ ТУУШИН ЗОНЧД БУУДАЛ, СОЁМНО ТАХИМ	 BB BANQUET SPONSOR 1,000,000 MNT ЛИЛИ НАРИТА УЛААНБААТАР РОТАРИ КЛУБЫН 2022-2024 ЕРӨНХИЙЛӨГЧ <i>Ротарийг дэмжжээ таниг баярлалаа</i> 2023-08-26 19:30 ЦАГТ ТУУШИН ЗОНЧД БУУДАЛ, СОЁМНО ТАХИМ	 BB BANQUET SPONSOR 2,000,000 MNT Б.САЙНЖАРГАЛ ТЭНГЭР РОТАРИ КЛУБЫН ЕРӨНХИЙЛӨГЧ, ХӨНӨНДӨ ТӨМӨРМӨСӨД ТӨСВИЙН ХАМНАЛ <i>Ротарийг дэмжжээ таниг баярлалаа</i> 2023-08-26 19:30 ЦАГТ ТУУШИН ЗОНЧД БУУДАЛ, СОЁМНО ТАХИМ
 BB BANQUET SPONSOR 2,000,000 MNT РАС Н. МЯГМАРЖАРГАЛ АНХНЫ АМО МОТИВАТ ССД <i>Ротарийг дэмжжээ таниг баярлалаа</i> 2023-08-26 19:30 ЦАГТ ТУУШИН ЗОНЧД БУУДАЛ, СОЁМНО ТАХИМ	 BB BANQUET SPONSOR 1,000,000 MNT ЗУУНМОД РОТАРИ КЛУБ <i>Ротарийг дэмжжээ таниг баярлалаа</i> 2023-08-26 19:30 ЦАГТ ТУУШИН ЗОНЧД БУУДАЛ, СОЁМНО ТАХИМ	 BB BANQUET SPONSOR 1,000,000 MNT Ч. ЖАРГАЛСАЙХАН ГУУАНСАЙХАН РОТАРИ КЛУБЫН ЕРӨНХИЙЛӨГЧ <i>Ротарийг дэмжжээ таниг баярлалаа</i> 2023-08-26 19:30 ЦАГТ ТУУШИН ЗОНЧД БУУДАЛ, СОЁМНО ТАХИМ
	 РОТАРИ ОДОР СПОНСОР 1,000,000 ₮ ДАМБАДОРЖЫН БОЛОРМАА БОГД РОТАРИ КЛУБЫН ҮҮСЭГН БАЙГУУЛАГЧ ЕРӨНХИЙЛӨГЧ РОТАРИЙГ ДЭМЖЭДЭГ ТАНИГ БАЙРЛАЛАА 2023.02.24 10:00 ЦАГТ Бие Сэйл Зочид Бүүдэл, Дайноч салт	
 DI PRESIDENT BANQUET SPONSOR 1,000,000 MNT B.NOMUUNBILEGT RI D3450 ASSISTANT GOVERNOR AIO <i>Ротарийг дэмжжээ таниг баярлалаа</i> 2023-11-11 18:30 ЦАГТ SHANGRILA HOTEL, BALLROOM	 DI PRESIDENT BANQUET SPONSOR 1,000,000 MNT B.CHIMEDLKHAM PRESIDENT OF ROTARY CLUB UB PEACE AVENUE <i>Ротарийг дэмжжээ таниг баярлалаа</i> 2023-11-11 18:30 ЦАГТ SHANGRILA HOTEL, BALLROOM	 DI PRESIDENT BANQUET SPONSOR 1,000,000 MNT ULAANBAATAR KHANGARID ROTARY CLUB <i>Ротарийг дэмжжээ таниг баярлалаа</i> 2023-11-11 18:30 ЦАГТ SHANGRILA HOTEL, BALLROOM
 DI PRESIDENT BANQUET SPONSOR 1,000,000 MNT KHUREE ROTARY CLUB <i>Ротарийг дэмжжээ таниг баярлалаа</i> 2023-11-11 18:30 ЦАГТ SHANGRILA HOTEL, BALLROOM	 DI PRESIDENT BANQUET SPONSOR 1,000,000 MNT J.GALBADRAKH IPAG, ROTARY CLUB OF KHUREE <i>Ротарийг дэмжжээ таниг баярлалаа</i> 2023-11-11 18:30 ЦАГТ SHANGRILA HOTEL, BALLROOM	 DI PRESIDENT BANQUET SPONSOR 2,000,000 MNT TS.ARIUNAA CP ROTARY CLUB OF SKY <i>Ротарийг дэмжжээ таниг баярлалаа</i> 2023-11-11 18:30 ЦАГТ SHANGRILA HOTEL, BALLROOM

2023-2024 ОНЫ ОЛОН УЛСЫН РОТАРИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ ГОРДОН МАКЛНАЛЛИ ГЭРГИЙ ХЕДЕР МКЛНАЛЛИ-ГИЙН ХАМТ МОНГОЛ УЛСАД АЙЛЧИЛЛАА, /2023НЫ 11 САРЫН 10-14/



Монголын Ротарийн гэр бүл болсон Ротари, Ротаракт, Интеракт клубуудийн гишүүд, дэмжигчидтэй уулзаж, тэдний хэрэгжүүлж буй гол гол төслүүдтэй танилцлаа



Монголын Улсын Их Хурлын Даргатай биечлэн уулзлаа





Rotary

Clubs of Mongolia



- Монголын Телевизүүдэд уригдаж Ротари байгууллагын тухай дэлгэрэнгүй ярилцлага өглөө
- ОУ Ротарийн 3450 Дүүргийн Захирагч Анди Ли-гийн “Захирагчийн Гал тогоо” шоу нэвтрүүлэгт оролцлоо.



ОУ-ын Ротарийн Ераөнхийлөгч-д зориулсан Хүндэтгэлийн Хүлээн авалт зохион байгуулав.



Шинээр байгуулагдсан 3 клубын Батламж, гэрчилгээ гардууллаа.



ОУ Ротарийн 3450 Дүүргийн 9, 10 Бүсийн Захирагч нарын Зөвлөлийн гишүүдтэй хүндэтгэлийн оройн зоог барилаа.

**ОУР-ЫН 3450 ДҮҮРГИЙН 2023-24 ОНЫ ДҮҮРГИЙН ЗАХИРАГЧ АНДИ
ЛИ, ГЭРГИЙ ЖЭЙН ЛИ БОЛОН ДҮҮРГИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХАМТ
2023 ОНЫ 8-Р САРЫН 25-30 НЫ ӨДРҮҮДЭД “ ЗАХИРАГЧИЙН АЛБАН
ЁСНЫ АЙЛЧЛАЛЫГ МОНГОЛ УЛСАД ХИЙЛЭЭ.**



- Монголын Ротари, Ротаракт, Интеракт клубуудийн гишүүд, төлөөлүүдтэй тэй тэдний хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаатай танилцлаа.



- Монголын Хэвлэл мэдээллийн сувгууд, телевизүүдэд Ротари байгууллагын тухай ярилцлага-нд оролцож яриа өглөө.

- Дүүргийн Захирагчийн нэрэмжит Хүндэтгэлийн Хүлээн авалт зохион байгуулав.
- Шинээр Ротарийн гишүүнд элсэж буй гишүүдэд, болон Ротари сангийн хандивлагч болсон Ротаричуудад Полл Харрис -ын батламж, энгэрийн тэмдэг гардуулах ёсдын арга хэмжээ боллоо.
- ОУ Ротарийн 3450 Дүүргийн 9, 10 Бүсийн Захирагч нарын Зөвлөлийнхэнтэй уулзаж ярилцлаа.



ОЛОЛН УЛСЫН РОТАРИЙН 3450 ДҮҮРГИЙН 2023-2024 ОНЫ
9-Р БҮСИЙН ЗАХИРАГЧ Б. САЛЬМА,
10-Р БҮСИЙН ЗАХИРАГЧ Б. НОМУУНБИЛЭГТ НАРЫН ХИЙСЭН
“БҮСИЙН ЗАХИРАГЧ НАРЫН АЙЛЧЛАЛ, УУЛЗАЛТУУД,



22 КЛУБИЙН 21 КЛУБУУДТЭЙ БИЕЧЛЭН УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ





БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЛБАН АЙЛЧЛАЛЫН ХҮРЭЭНД ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГУРВАН САЙХАН РОТАРИ КЛУБТ ЗОЧИЛЖ, ОРОН НУТАГТАА ХЭРЭГЖҮҮ БҮЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮДТЭЙ НЬ ТАНИЛЦЛАА.



МОНГОЛ ОРОНД ҮҮССЭН ҮЕРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД РОТАРИЧУУД ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЛЭЭ

2023 оны 7-р сард хүчтэй үргэлжлэн орсон борооны улмаас Монгол улс, Улаанбаатар хотод гэнэтийн үерийн нөхцөл байдал үүсч бэрхшээл хүндрэл бий болсон.

Олон Улсын Ротарийн 3450 (Хонгконг, Макао, Монгол, Гуандун) Дүүргээс энэхүү нөхцөл байдалд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх санаачлага гарч хандивын аянаар нийт 35,224,31 ам.долларын (121.980.712 MNT -тэй тэнцэх) мөнгөн хандив цугларсан.

Хандивын тусламжаар үерийн гамшигт илүүтэй өртсөн байгууллага, албан газар зэрэг 7 тухайлсан объектод яаралтай тусламж үзүүлэн, үерийн гамшигийг арилгах, хэвийн үйл ажиллагаанд нь оруулах, нөхөн сэргээх, аюул гамшигт өртсөн ард иргэд, үерт өртсөн айл өрхөд тусламж үзүүлэх, үерийн дараах ариутгал, хөрсний болон орчны бохирдол цэвэрлэх, хуримтлагдсан хог, лаг зайлуулах зэрэг ажлын дараалал гарган ажилласан.



РОТАРИЧУУДЫН ХАНДИВ ТУСЛАМЖААР:

1. Баянзүрх дүүргийн ОБГазарт өндөр хүчин чадал бүхий үерийн ус, шороо сорох насос мотор Хонда WT30X төхөөрөмж, холбох шланг, сорох шланг,
2. Хүүхдийн Паркийн үерт автсан хэсгийн лаг шавар, нуурт хуримтлагдсан хог, бохир ус зайлуулах, хэвийн үйл ажиллагааг хангах, сэргээн босгох ажиллагаанд зориулж,
3. Баянзүрх дүүргийн Хөдөлмөр, Халамж Үйлчилгээний хэлтэстэй хамтран үерийн гамшгийн үеэр орон гэргүй болсон Баянзүрх дүүргийн 21, 27, 29 -р хорооны 5 айлд иж бүрэн монгол гэр хандивлах,
4. Цэцэрлэг хүрээлэн дэх Ротари тоглоомын талбайн нөхөн сэргээлтийн, засвар арчлалтын ажил болон талбай, орчны ариутгал цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийж гүйцэтгэхэд,
5. Ротари Мэдээллийн Төв байрладаг Юнион Бюльдинг барилгад үүссэн үерийн дараах нөхөн сэргээлт, цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт ажилд зориулж
6. Төв аймгийн Зуунмод сумын 6-р багт үерийн улмаас үүссэн замын эвдрэлийг засах, нөхөн сэргээх ажилд зориулж,
7. ХУД-т байрлах 209-р цэцэрлэгийн үерт автсан нэг давхрын анги танхим, спорт заалны нөхөн сэргээх, засварлах ажилд зориулж хандивын тусламжийг зарцуулан ажилласан.



END POLIO АЛХАЛТ

Ротаричууд 35 гаруй жилийн турш “Халдварт Саа буюу полиомелит” өвчнийг устгах хөтөлбөр хэрэгжүүлж ажиллаж байна. 2023-24 оны Ротарийн жилд Монголын Ротари, Ротаракт, Интеракт клубуудын 130 гаруй гишүүд, гэр бүл, найз нөхдийн хамт 2023- оны 10-р сарын 7 ны Бямба гарагт зохион байгуулагдсан “Саажилтыг одоо дуусгая” АЛХАЛТ-нд амжилттай оролцож Дэлхийн Ротаричуудтай нэгдэж Ротари санд хандив өргөлөө.



“АЛХАЛТ”-ын үеэр уламжлал ёсоор хог түүж, орчноо цэвэрлэж, хамтдаа цагийг сонирхолтой, хөгжилтэй өнгөрөөлөө. Уг арга хэмжээг зохион байгуулсан Улаанбаатар Пийс Авеню Ротари клубдээ Баярлалаа. Мөн амжилттай оролцсон, мөнгөн хандив өгч дэмжсэн бүгдэд нь баярлалаа.



“РОТАРИ СПОРТ ӨДӨРЛӨГ”

“Ротари Спорт өдөрлөг” нэрийн дор жил бүр уламжлал болгон зохиогддог спортын арга хэмжээг 2023-24 оны Ротарийн жилд өмнөх жилийн цомын эзэн Хүрээ Ротари клуб 2023 оны 10-р сарын 28, 29 ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж аваргуудаа тодрууллаа.



Спортын 5 төрлөөр /сагсан бөмбөг, гар бөмбөг, дартс, шатар, ширээний теннис/зохион байгуулагдсан 2023-24 оны Цомын эзэн багийг тодруулах тэмцээнд Хүннү Ротари клубын гишүүд манлайллаа.

Ротарийн тамирчиддаа баяр хүргэж амжилт хүсье.



РОТАРИ ШИНЭ ЖИЛ

2023 оны 2 сарын 9нд бүх Ротаричуудын “Гялтгар” сэдвээр Нэгдсэн Шинэ Жилийг Тэнгэр Ротари клуб маань гялтгар зохион байгуулсанд Баярлалаа. 21 клубуудийн 200 гаруй гишүүд цуглан инээд хөөр, баяр баяслаар дүүрэн нэгэн үдшийг хамтдаа өнгөрүүлээ.



ДЭЛХИЙН РОТАРИ ӨДӨР МОНГОЛД

1905 оны энэ өдөр АНУ-ын Иллинойс мужийн Чикаго хотод Пол Харрис хэмээх эрхэм өөрийн нөхдийн хамт Ротари хөдөлгөөний үндсийг тавьснаас хойш Ротари хэмээх дэлхийн хамгийн анхны ашгийн бус, хүмүүнлэгийн энэ байгууллага өдгөө 119 жилийн дотор 200 гаруй улс оронд 46,000 клубтэй, 1,4 сая гишүүнтэй болоод байна.



Олон Улсын Ротарийн 3450 дүүргийн 9,10-р Бүсийн удирдлагын баг, Ротаричууд, Ротарактууд, Интерактууд, Ротариг дэмжигчид болон Ротари хөдөлгөөний үр шимийг хүртэгчдийн хамт “Ротари Өдөр” -24 арга хэмжээг Монгол орондоо 2024 оны 2-р сарын 24-ний өдөр амжилттай тэмдэглэн өнгөрүүлээ.

“Өөрөөсөө давж бусдад туслахыг” уриалдаг Ротари байгууллага гишүүдийнхээ

хүмүүнлэгийн сайн сайхан үйлсийг олон нийтэд түгээх, тэдний сайн дураар, өөрсдийн санаачлагаар хийж, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийг сурталчлан таниулах, бие биенээсээ харилцан суралцах, нөхөрлөх зорилготой энэхүү өдрийн арга хэмжээ амжилттай зохион байгуулагдсан ба дэмжин оролцсон Монголын Ротаричууддаа гүн талархал илэрхийлье.



РОТАРИ ЗОЛГОЛТ

17-р жарны Модон Луу жилийн Хаврын тэргүүн сарын Шинийн 8-ны билэгт сайн өдөр 2024 оны 2-р сарын 17-нд Монголын Ротарийн Бүсийн удирдлагын баг, клубын Ерөнхийлөгч нар “Ротари Цагаан Сар” арга хэмжээг зохион байгуулж, Ротарийн анхдагч, ахмад гишүүдээ хүндэтгэн золгож дотно сайхан арга хэмжээ боллоо.



ИНТЕРАКТ 9, 10 БҮСИЙН 3Х3 САГСАН БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭН

ОУ Ротарийн 3450 Дүүргийн Залуучуудын хорооноос анх удаа Бүх Интерактуудын дунд 3х3 Сагсан бөмбөгийн тэмцээн санаачилсан бөгөөд Монголд Монголын Интеракт клубуудын дунд уг тэмцээнийг 2024 оны 3-р сарын 10 –ний өдөр 9, 10 Бүс Ээж Ротари клубуудын дэмжлэгээр зохион байгуулсан юм.

Нийт 19 Интеракт клубуудээс 17 клубийн 33 багийн нийт 250 гаруй Интерактууд оролцсон хамгийн том арга хэмжээ болсон.

Эрэгтэй ялагч багууд:

- 1-р Байр – 23-р Сургууль Интеракт клуб, Ээж клуб нь Улаанбаатар Пийс Авеню
- 2-р Байр – Хүрээ Коосэн Интеракт клуб, Ээж клуб нь Хүрээ Ротари клуб
- 3-р Байр – Хобби Интеракт клуб, Ээж клуб нь Улаанбаатар Ротари клуб

Эмэгтэй ялагч багууд

- 1-р Байр – Зуунмод Интеракт клуб, Ээж клуб нь Зуунмод Ротари клуб
- 2-р Байр – Шинэ Монгол Интеракт клуб, Ээж клуб нь Хүрээ Ротари клуб
- 3-р Байр – АШУУИС-ын Лицей Интеракт клуб, Ээж клуб нь Улаанбаатар Нарлаг Ротари клуб



1-р байрны 2 баг 3450 Дүүргийн тэмцээнд оролцох эрх авсан ба хүүхдүүд болон багш нарын зардлыг 3450 дүүрэг, 9,10 бүс болон Ротари клубууд гаргасан. Дэмжэн тусалсан бүх Клубууддээ **БАЯРЛАЛАА**

3450 ДҮҮРГИЙН 3Х3 САГСАН БӨМБӨГИЙН АВРАГУУД

Хонг Конг, Макау болон Монголоос шалгарсан багууд 2024 оны 3-р сарын 29 –30 өдрүүдэд Хонг Конгт ДҮҮРГИЙН АВРАГА шалгаруулах тэмцээнээр Монголын эрэгтэй, эмэгтэй 2 багууд маан 2 лаа АВРАГА болсон.

- Эрэгтэй Аврага баг – 23-р Сургууль Интеракт клуб, Ээж клуб нь Улаанбаатар Пийс Авеню
- Эмэгтэй Аврага баг - 1-р Байр – Зуунмод Интеракт клуб, Ээж клуб нь Зуунмод Ротари клуб

Хүүхдүүдийн болон багш нарын зардлыг гаргаж дэмжсэн ОУ Ротарийн 3450 дүүрэг, 9&10 бүс болон Ротари клубууддээ БАЯРЛАЛАА



ДҮҮРГИЙН КОНФЕРЕНЦИ, ХОНГ КОНГ

ОУР-ын 3450 Дүүргийн 64 дэх удаагийн хурал 2024 оны 5-р сарын 18-19 ний өдрүүдэд Хонг Конгын Регала Скай Сити зочид буудалд боллоо.

Дүүргийн хурлын үеэр:

1. Гишүүнчлэл
2. Ротари Сан
3. Ротари Брендинг
4. ДЕАЙ/Эрүүл мэнд
5. Залуучууд/Мэргэжлийн салбар сэдвүүд дээр онцолж салбар хуралдаанууд зохион байгуулагдлаа.



Дүүргийн 64 дэх удаагийн хуралд Монголын Бүсээс 5 клубын нийт 20 гаруй Ротаричууд оролцлоо. УБ Ротари клуб, Зуунмод Ротари клубуудын төсөл “Дүүргийн шилдэг 10” төслийн уралдаанд шалгарч шагнал хүртлээ.

УБ Централ клуб нь “Ger for Life” онцлогх төслөөрөө манлайлж, мөн зургийн уралдаанд шагналт 2-р байрт шалгарч өргөмжлөл мөнгөн шагналын эзэн боллоо.



ОЛОН УЛСЫН РОТАРИЙН ЧУУЛГА 2024 СИНГАПУР УЛС

Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн Ротаричууд, Ротаракт, Интерактууд 2024 оны 5 сарын 25-30 хооронд Сингапур улсад зохион байгуулагдсан Олон Улсын Ротарийн чуулганд амжилттай оролцлоо.

Дэлхийн даяаар 1,4 сая гишүүнчлэлтэй Ротари гэр бүлийн 200 гаруй улс орнуудаас 14,000 гаруй Ротаричууд, Ротаракт, Интерактууд цуглан Нийгмийн, Хүмүүний төлөөх төсөл хөтөлбөрүүдээ болон ирээдүйн

сайн сайхан төлөө хийх ажлуудаа танилцууллаа.

Монголын Ротари, Ротаракт, Интеракт клубуудийн 40 гаруй гишүүд дурсамж дүүрэн амжилттай аялаад ирсэн ба Монгол улсаа төлөөлөн оролцсон та бүхэндээ Баярлалаа.

Өөрөөсөө давж бусдад туслах сэтгэл, санаа нэгт хүмүүс нэг дор цуглаж найз нөхөрлөл, урам зориг бүхнийг бий болгосон маш сайхан Чуулга боллоо.



СУРГАЛТЫН ХОРОО

Шинэ Ерөнхийлөгчдийн сургалт (CP Academy) 2 удаа хийгдэж нийт 45 гишүүд оролцсон. Нийт 4 шинэ клуб үүссэн.



Клубийн үйл ажиллагааг сайжруулах нийт 3 (УБ, Нийслэл, Номт) клубүүд сургалт авсан. Сонгогдох Ерөнхийлөгчдийн сургалт PETS ээс өмнө 2 удаа хийгдэж нийт 60 аад гишүүд сургалтад хамрагдсан.



ГИШҮҮНЧЛЭЛИЙН ХОРОО

2023-2024 РОТАРИ ЖИЛД ШИНЭ ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН 4 ШИНЭ КЛУБУУДДЭЭ БАЯР ХҮРГЭЭ!




Welcome on Board !

- Мөрөн Хүрээ Ротари Клуб
- Хүннү Ротари Клуб
- Шинэ Гүүр Ротари Клуб
- Хангай Ротари Клуб



Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн 9, 10 Бүсийн Гишүүнчлэл



ЗАЛУУЧУУДЫН ХОРОО

Энэ Ротари жил 9, 10 дугаар бүсийн Залуучуудын хувьд өрнөл ихтэй, олон төсөл хамтралтай онцлог жил болж өнгөрлөө. Эдгээрээс нэгтгэн дурдваас:

- Ротаригийн нас насны ангиллын (Ротари, Ротаракт, Интерактууд) үе хоорондын хамтралууд сайн байв. Бүсийн удирдлагын дэмжлэг их байсан нь чухал үндэс байв. Олон арга хэмжээ, төслүүдэд хамтран оролцсоны нэг онцлогуудтай нь Ротарактууд анх удаа Global Grant төсөлд албан ёсоор хамтран оролцсон явдал.
- Ротари бүс, дүүрэг, клуб, олон улсын хамтралууд өргөжив. Үүнд: Олон улсын Ерөнхийлөгчийн аялал, Японы дүүргүүдийн Ротаракт төвтэй айлчлалыг хүлээж авсан, хувь клубуудын өөрсдийн болон ээж клубуудтэйгээ хамтран эхлүүлсэн холбоос, хамтралууд
- Төслийн, спортын болон төслийн бус бусад арга хэмжээ болон бүх нийтийн ойлголтыг сайжруулах санаачлагууд. Олон нийтэд мэдээлэл өгөх олон хэлбэрт санаачилгууд: Ротари өдөр, Ротаракт 7 хоногоор дотоод болон олон улсын хамтрагчдын оролцоо нэмэгдсэн.

- Шинэлэг, анхдагч үйл явдал олонтой байснаас дурдваас: Интеракт клубүүдийн дунд бүсийн дүүргийн зүгээс 3x3 сагсны бүс, дүүргийн түвшний тэмцээн анх удаа зохион байгуулагдав. Ротари-ПАК хамтран Интеракт клубыг спонсорлолоо. Интеракт клубыг байгуулах, гишүүдийг болон тэдний хэрэгүүлэх төслийн саналыг сонгон шалгах ажлыг тусдаа төслийн түвшинд маш хариуцлагатайгаар хийсэн сайн жишиг бий болов. Анхны Жуниоракт клуб байгуулагдах зөвшөөрлөө авав.
- Тогтмол хийгддэг төсөл болон арга хэмжээнүүдийг өргөжүүлэхийн сацуу илүү чанар дээр анхаарах санал санаачилгуудыг хэрэгжүүлэн ажиллав. Жишээ нь: бүх Интеракт клубууд оролцсон ном орчуулгын төслийг хамтрагч байгууллагатай хоёр дахь удаагаа хийхдээ шинээр байгуулагдсан Интеракт клубийн сургууль дээр хамтран спонсорлосон Ротаракт клуб хамтран зохион байгуулахдаа мэргэжлийн багш нарыг урин оролцуулав. Ротарактууд шилдгээ шалгаруулах журмаа санаачлан, нээлттэй хамтран хэлэлцсээр, эцэслэн баталсан.



Эдгээрээс ажиглагдсан болон ирэх Ротари жил илүү анхаарах зарим зүйлсээс дурдваас:

- Хүүхэд хамгааллын асуудал бүхий л олон төсөл, ажиллагааны цөм тул энэ тухайд онцгойлон анхаарч ажиллах. Ирэх жил намар энэ чиглэлийн сургалтууд хийж дүрмүүдийг дахин танилцуулан ажиллах болно.
- Клуб, гишүүд, төсөл арга хэмжээний тухайд тооноос илүү чанар болон урт хугацааны тууштай байдалд анхаарах хэрэгцээ шаардлага үүссэн. Интеракт, Ротаракт клубын ээж клубууд спонсорлосон клубуудтэйгээ хангалттай анхаарч, хамтарч ажиллах шаардлагатай. Мөн шинээр клуб спонсорлахын өмнө тухайн санаачилгыг гаргаж буй спонсор/эцэг эх клубын өөрийн бэлэн байдал төлөвлөгөөг анхааран үзэх зайлшгүй шаардлага үүссэн байна.
- Бүх үеийнхэн аливаа ажил арга хэмжээ, хамтралдаа өөр өөрийн онцлог, ур чадваруудаар оролцох нь үр дүнтэй зохилт байгуулагдаж чадваас бие биесээ нөхөж, ачааллаа багасгаж чаддаг тул эдгээр хамтралыг үр дүнтэй байлгаж, шаардлагагүй (давхардсан болон орхигдсон) ажиллагаа багатай байлгахын гол үндэс нь харилцаа холбоо, мэдээлэл солилцоо болно. Энэ нь ажлыг хангалттай эртнээс төлөвлөн мэдээллийг холбогдогч бүх талуудад нэгдсэн журмаар хүргэхээс эхлэх зэрэг төслийн менежментийн үндсэн алхмуудаар дамжин хэрэгжих боломжтой. Мөн тухайн ажлыг албан тушаалаар болон уг төслийн тухайд хариуцан авсан гишүүд хариуцлагатай байх нь анхдагч.



Залуучуудын дэд хороо ажлаа үр дүнтэй хэрэгжүүлэхэд эхнээс нь хамт төлөвлөн дэмжин хамтран амьдарч “Итгэл найдварыг бүтээлцсэн” Бүс, дүүрэг, олон улсын Ротари захирагчид, удирдлага, клубын албан тушаалтнуудад талархал илэрхийлэхийн сацуу “Ид шидтэй жилд” амжилт хүсэе.



РОТАРИ САНГИЙН ХОРОО

Товчлол: РС- Ротари Сан, ДРСХ -Дүүргийн Ротари Сангийн Хороо




1. РС хандив : 100% EREY клубууд (2023 оны 11-р сарын 5-ны байдлаар)

- 9-р бүс : Баянзүрх, Нарлаг Улаанбаатар, Улаанбаатар, Улаанбаатар тэнгэр
- 10-р бүс : Хүрээ, Улаанбаатар төв

2. Дүүргийн Грант-д хүсэлт гаргаж урьдчилан батлагдсан клубууд

- 9-р бүс: Улаанбаатар, Нарлаг Улаанбаатар, Номт, УБ Пийс Авенью, Баянзүрх, Тэнгэр, Их үнэр
- 10-р бүс: Зуунмод, Улаанбаатар Централ, Гурвансайхан

3. Глобал Грант төслүүд (одоо хэрэгжиж байгаа)



1	GG1874623	Улаанбаатар Пийс Авенью РК (D3450)	Монголын анхны төрөлт симуляцийн төв	Төсөв: 188,893 доллар
2	GG2011973	УлаанбаатарРК (D3450)	Гепатитгүй Монгол, 2-р шат	Төсөв: 191,331 доллар
3	GG2119832	СэлбэРК (D3450)	Амьсгалын замын өвчнийг эрт оношлох. Монголын эмч нарыг сургах.	Төсөв: 38,500 доллар
4	GG2344263	ХүрээРК (D3450)	Түрүү булчирхайн лазер мэс засал	Төсөв: 74,800 доллар
5	GG2346883	Хүрээ РК (D3450)	Монголын номын сангийн төсөл	Төсөв: 32,800 доллар
6	GG2457015	УлаанбаатарРК (D3450).	Хөгжингүй орнуудын эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтын 3-р үе шат	Төсөв: 107,000 доллар
7	GG2458085	Их ӨргөөРК (D3450)	Ухаалаг сэтгэцийн эрүүл мэнд	Төсөв: 31,040 доллар
8	GG2454666	ХүрээРК(D3450)	Тархины судасны эмгэгийн мэс заслын эмчилгээний чанарыг сайжруулах	Төсөв: 85,988 доллар



4. Грант Менежмент Семинар монгол хэл дээр 2024 оны 6-р сарын 8-нд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан. TRF-ийн үндсэн ойлголтууд, дүүргийн грант, глобал гранттэтгэлэг, РС-ийн хөтөлбөрүүд, Хариуцлага, Санхүү, Аудит гэсэн агуулгууд багтсан ба 2021-24 оны ДРСХ-ны дарга PDG Белинда Янг, PDG Вилсон Ченгийн удирдлага дор сургалтын багт РАГ Б.Булган (2023-24 онд ДРСХ-ны Монголыг хариуцсан дэд дарга), РАГ А.Мөнхжаргал (2024-25 оны ДРСХ-ны Монголыг хариуцсан дэд дарга), РАГ Х.Жамбалмаа (2024-25 оны ДРСХ-ны Монголын дэд хорооны гишүүн), РР С.Нармандах (2024-25 оны ДРСХ-ны Монголын дэд хорооны гишүүн) нар ажиллав. Тус семинарт оролцогчдын тоо 69 байсан ба, үүнд 22 клуб/шинэ клубын 54 Ротарийн гишүүд мөн 8 Ротаракт клубын 15 гишүүд оролцосноор өөрийн клубийн Ротарийн Грант хөтөлбөрт оролцох шалгуурын нэгийг хангалаа.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХОРОО

Олон Улсын Ротари байгууллага цус хандивлах өдөрлөг

2023-2024 оны Ротарийн жилийн Цусны өдөрлөг нь 2024 оны 5-р сарын 11 ны өдөр Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв дээр зохион байгуулагдаж Ротаричууд, Ротарактууд өргөнөөр оролцсон. Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь сар бүрийн 3-ны өдрийг “Цусаа бэлэглэх өдөр” болгосон ба Зуунмод Ротари клуб Зуунмод хотод уг арга хэмжээнд тогтмол нэгддэг бол олон Ротаракт, Ротаричууд хүндэт донор болсон байна.



“Мөнхөд цохилох зүрх” эс эд, эрхтэн шилжүүлэн суулгалтын Олон Улсын хурал

Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн Эрүүл Мэндийн Хорооны 2023-24 оны зорилтуудын нэг нь “Эрхтэн Донорын салбар хороо байгуулан олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах, дэмжин оролцох, эрхтэн донорын тухай ойлголтыг нэмэгдүүлэх явдал юм.




Энэхүү зорилтын хүрээнд 9-10-р бүсийн эрхтэн донорын дэд хороо болон Монголын Ротаричууд 2023-24 оны Ротарийн жилд Эрхтэн Донорын үйл ажиллагааг зохицуулах албатай хамтран “Мөнхөд цохилох зүрх” олон нийтийн арга хэмжээнд хамтран оролцож, 2024 оны 5-р сарын 24-25 ны өдрүүдэд Улаанбаатар хотноо болсон Эс эд, эрхтэн шилжүүлэн суулгалтын Олон Улсын хуралд 20 гаруй Ротаричуудын төлөөлөл хамрагдлаа.



ВИРТУАЛ СУРГАЛТ, СОЛИЛЦООНЫ ХОРОО

Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн Виртуал сургалт, солилцооны хорооноос зохион байгуулсан 9213 Дүүргийн Уганда улстай Виртуал Туршлага Солилцох цахим уулзалтанд 3450 Дүүргийн 9-р Бүсийн захирагч Б.Сальма илтгэгч болж оролцсон ба Залуучуудын хорооны дарга Х.Ариунгоо дэмжин оролцосонд баярлалаа.



ОЛОН ТАЛТ, ЭРХ ТЭГШ, ОРОЛЦООТОЙ ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД “ABILITY EXPO 2023” АРГА ХЭМЖЭЭ

Бид Олон Улсын Ротарийн үндсэн үйл ажиллагааны чиглэл болох Олон талт, эрх тэгш, Оролцоотой чиглэлийн хүрээнд 2023 оны 11-р сарын 26-ны өдөр хувийн хэвшил, төрийн байгууллага хамтран Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Нэгдсэн Экспо “Ability Expo 2023” 2 дахь жилдээ зохион байгуулагдаж буй арга хэмжээний зохион байгуулалтанд оролцоо.

Энэхүү экспо арга хэмжээ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмд эерэгээр сурталчлан танилуулах, тэдгээр иргэдийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглэсэн технологийн шийдлүүдийг танилцуулахад чигэлсэн бөгөөд Ротари байгууллагыг төлөөлөөд Улаанбаатар Цэнтрал ротари, Гэрэгэ Ротари, Улаанбаатар Цэнтлал Ротаракт, СЭЗИС Ротаракт, Цаст Ротаракт, 115 сургуулийн Интеракт, Бритиш Сургуулийн Интеракт клубууддээ Баярлалаа.



ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, НОГООН ХОРОО

Хүрээлэн буй орчныг хамгаалах, сайжруулах асуудал Олон Улсын Ротари байгууллага байгуулагсан цагаас хойш ротари үйлчилгээний төвд нь байсан. 1990 онд Олон улсын Ротари байгууллага “Дэлхийг хамгаалах хөтөлбөр”-ийг баталсан.

Монгол Улсын ротаричуудын харьяалагддаг ОУР-ийн 3450 дүүрэг нь Хүрээлэн буй орчныг хамгаалах ажлын 2023-2024 оны төлөвлөгөөг гаргахдаа тухай улс орны байгаль орчны байдал, үүсээд байгаа асуудалд анхаарал хандуулахыг зорьсон юм.

2023-2024 онд хийгдсэн ажлуудаас дурьдахад:

1. Жил бүрийн мод тарих өдөр буюу 2023 оны 10 дугаар сарын эхний 2 долоо хоногт Монголын Ротари клубууд халиас, улиас, чацаргана, нарс, долоого зэрэг олон төрлийн 5 880 ш модыг Улаанбаатар хотын Богд-уул, Тэрэлж, Багахангай дүүрэг, Сүхбаатар аймаг, Хөвсгөл аймагт тарьсан байна.
2. ОУР-ийн 3450 дүүргийн хэмжээнд 2023 оны 10 дугаар сарын 28-ны өдөр “POWER DAY” өдөрлөг нэгдсэн жураар зохион байгуулагдсан ба монголын ротари, ротаракт, интеракт гурван үеийн 50 гаруй гишүүд, ротарийн гэр бүлийнхэн,

хүүхдүүд оролцсон. Арга хэмжээнд дөрвөн зочин илтгэгчид нүүрстөрөгчийн хийг бууруулах, хүнсний хог хаягдал, байгаль орчныг хамгаалах сэдвээр илтгэл тавьж, байгаль орчны залуу судлаач хүүхдүүдийн баг байгаль орчныг хамгаалах бодит туршилтуудыг хийж, оролцогч нарыг хамруулснаар арга хэмжээ хөдөлгөөнтэй, сонирхолтой, сургамжтай болж өндөрлөсөн.

3. ОУР-ийн 3450 дүүрэг зарласан ROTARY CLEAN DAY өдөрлөгийг 2024 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр Улаанбаатар хотын Цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулагдсан. Арга хэмжээд Бүгд Найрамдах Чех Улсын “Каритас” ТББ, Европын Холбооны “SWITCH-Asia” хөтөлбөрийн “Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах (SPRIM)” төсөл, Alliance Française d'Oulan-Bator буюу Монгол-Францын төв зэрэг байгууллагуудтай хамтран оролцсон. Уг арга хэмжээнд 350 гаруй хүн оролцсоны 247 нь Ротари, Ротаракт, Интеракт, Ротари клубын гишүүдийн гэр бүлийн гишүүд, найзууд байв. Ротари цэвэрлэгээний өдрөөр нийт 130 уут хог хаягдлыг цуглуулж, Ротари хүүхдийн тоглоомын талбай дахь тоглоомуудыг сэргээн будсан.



RMB Mongolia буюу Монголын бизнес эрхлэгч Ротаричуудын холбоо нь бизнес эрхлэгч Ротари, Ротарактуудын бизнесийг дэмжих зорилготой байдаг бөгөөд Монголд Дэлхийн Ротари Өдрөөр 2024.02.24 өдөр анх танилцуулагдаж нээлтээ хийсэн билээ. RMB гишүүд 7 хоног бүр уулзалт хийж өнөөдрийн байдлаар нийт RC of New Bridge, UBPA, Hunnu, UB, Sky, Narlag UB болон RAC Tsast, Tsetsee Gun-с нийт 20 албан ёсны гишүүдтэй үйл ажиллагаа явуулж байна. Өнгөрсөн хугацаанд харилцан бие биенээ дэмжиж 50 илүү сая төгрөгийн борлуулалт хийгдсэн байгаа.





A collage of 20 photographs showcasing various activities of the Rotary Club of Mongolia. The images include: group photos of members and guests at formal events; award ceremonies where members receive recognition; community service projects such as tree planting and environmental cleanups; and meetings or presentations in conference rooms. The photos are arranged in a grid-like fashion, highlighting the club's diverse and active membership.

УЛААНБААТАР РОТАРИ КЛУБ



ЛИЛИ НАРИТА

Улаанбаатар Ротари клубийн 2023-2024 Ерөнхийлөгч

Улаанбаатар Ротари клуб нь 1995 онд үүсгэн байгуулагдсан Монголын ууган ротари клуб бөгөөд 2023-2024 оны Ротарийн жилд 32 идэвхтэй гишүүнтэй, 100% PHF, 100% EREY клуб юм. Мөн энэ жилийн онцлог нь анх удаа Монголоос төрсөн Major Donor манай клубээс төрсөн явдал байлаа. Жилийн турш нийт 2800 хүн цагийг зарцуулж нийгэмд тустай олон төслийн санаачлагч, хэрэгжүүлэгч, дэмжигч, болон спонсор болон ажиллалаа.

2023-24 Ротари жилд бид өөрсдийн нэрийн хуудас болсон томоохон төсөл, хөтөлбөрүүдээ үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн төдийгүй шинэ төслүүд хэрэгжүүлэх бэлтгэл ажлаа ч амжилттай хангаад байна. Үүнд:

1. 2003 оноос хойш өнөөг хүртэл хэрэгжүүлж буй ЕБС-д эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн өрөө, халуун усны газрыг байгуулж, улмаар сурагчдыг халдварт өвчнөөс сэргийлэх зорилготой “Сургуулийн ариун цэврийн байгууламж” төслөө энэ жил ч мөн Ротари Сангийн глобал грантаар 5 сургуульд нэмж хэрэгжүүлэхээр болсон ба Улаанбаатар хотын 29 болон 85-р сургууль, Дундговь аймаг, Өвөрхангай аймаг болон Сэлэнгэ аймгийн Мандал сумдуудад тус тус

хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Төслийн нийт төсөв \$49,000 ам.доллар.

2. 2016 оноос хойш хэрэгжүүлж буй “Гепатитгүй Монгол” төсөл маань Ротари Сангийн глобал грантын хүрээнд үргэлжилж Сүхбаатар аймгийн олон сумдад хүрч ажиллан 4000 гаруй иргэдийг урьдчилсан шинжилгээнд хамруулж, элэгний сургагч бэлдэж ажиллалаа. Уг төсөл хэрэгжиж эхэлсэн цагаас эхлэн шууд үр шимийг хүртэгсдийн тоо 120,000 хүрээд байна. Мөн 5-р сарын 18, 19-нд зохион байгуулагдсан ОУ-ын Ротарийн 3450 дүүргийн хуралд “Гепатитгүй Монгол” төсөл маань дүүргийн шилдэг төсөл болсон гайхалтай мэдээг хүлээн авсан юм.
3. 2011 оноос хойш хэрэгжүүлж буй “Агаа Эгээ” төслийг энэ жил манай клуб дэмжин ажилласан бөгөөд Дүүргийн грантаас амжилттай төсөв батлуулж чадсан юм. Хөтөлбөрийн хүрээнд 20 хүүхэд хамрагдсан ба нийт агаа, эгээ нарын 3 нь манай клубын гишүүд өөрсдөө байсан нь онцлог байлаа.
4. Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн Ротарийн нэрэмжит тоглоомын талбайг сэргээн засварлах, эвдэрч муудсан тоглоомыг дахин шинэчлэх ажлыг хийж байна.
5. Улаанбаатар Ротари клубын хүндэт гишүүн агсан Эгүчи сангийн нэрэмжит номын санг нийслэлийн 38-р цэцэрлэгт байгуулахаар ажиллаж байна.
6. СХД-ийн Хараагүйчүүдийн төв өнгөрсөн зун үерт автсан ба уг төвийн байрыг засварлахаар хамтран ажиллаж байна.

Манай клуб нь олон Ротари, Ротаракт, Интеракт клубын “ээж” клуб бөгөөд энэ жил Улаанбаатар дахь Австралийн Ухаалаг сургууль болон Оргил сургуульд шинээр интеракт клубтэй болоод байна.



ИХ ӨРГӨӨ РОТАРИ КЛУБ



Г. УЯНГАА

Их Өргөө Ротари клубийн 2023-2024 Ерөнхийлөгч

Их Өргөө Ротари клуб нь 2012 оны 6 сард байгуулагдаж, байгуулагдсанаас хойш 10-20 гишүүнтэй, клубийн 10 гишүүн Paul Harris хүртсэн. 2023 онд Малайз улсын Мелавата ротари клубтэй систер клуб болсон. Манай клуб 1 ротаракт клуб болон 1 интеракт клубийг үүсгэн байгуулсан.

Бид шаардлагатай эмнэлэгийн тоног төхөөрөмжөөр нийслэлийн болон хөдөө орон нутгын эмнэлэгүүдэд туслалцаа үзүүлж ирсэн. Бидний хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж байгаа төслүүд:

- 2013-2018 он “Ургын Монитор” төсөл /ургын монитор тоног төхөөрөмж хандивлах/

- 2019-2020 “Сумдын эмнэлэгийн хуучин ор шинэчлэх” төсөл /шинэ ор хандивлах/
- 2023 ROOT project, U-CHAMP Local project Local project
- 2023 Prostate Laser Surgery equipment donation project /GG2344263/
- 2022-2024 Second wind DG project
- 2024-2025 MIND FREE Local project
- 2024-2025 SMART MENTAL HEALTH PROJECT /GG2458058/

MIND FREE төсөл нь 7-12-р ангийн 5,000-6,000 орчим өсвөр үеийнхний сэтгэл хөдлөл, зан үйлийг илрүүлж, сургуулийн сэтгэл зүйчид, эмч нарт хүүхлийн сэтгэл зүй, сэтгэл заслын мэргэжлийн сургалт явуулахыг зорьж байна. Мөн хүүхдийн сэтгэл зүй, сэтгэл зүйн анхан шатны тусламжийн гарын авлагыг бэлтгэх, түгээх юм.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Орон нутгын аймаг сумды эмнэлгүүдийг ханиад томуунаас өмнө шаардлагатай хэмжээний зөөврийн хүчилтөрөгч өтгөрүүлэгч төхөөрөмжөөр хангах.



УЛААНБААТАР ПИЙС АВЕНЬЮ РОТАРИ КЛУБ



Б. ЧИМЭДЛХАМ

Улаанбаатар Пийс Авенью Ротари клубийн 2023-2024 Ерөнхийлөгч

Улаанбаатар Пийс Авенью Ротари Клуб нь анхны Ротарактуудаас байгуулагдсан Ротари клуб бөгөөд энэ жил 11 жилийн ой тохиож байна. Улаанбаатар Пийс Авенью Ротари Клуб нь 2023-2024 оны жилд 28-45 насны нийт 24 албан ёсны гишүүдтэй, мөн 30 гаруй дэмжигч гишүүдтэй, бүх гишүүд маань гададын олон улсад их дээр сургууль төгссөн залуус байдаг бөгөөд албан хурал үйл ажиллагаагаа Англи хэл дээр явуулдаг.

Улаанбаатар Пийс Авенью Ротари Клуб нь байгуулагдсан цагаасаа эхлэн Монгол Улсдаа эрүүл мэнд, боловсрол, ундны усны асуудалд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байгаа бөгөөд өнгөрсөн 11 жилийн хугацаанд Олон улсын Ротари Сан, Ротари дүүргийн сан, Олон улсын Ротари Клубүүд болон бусад хамтрагч байгууллагуудынхаа дэмжлэгтэйгээр нийт 1.5 сая ам.долларын санхүүжилт бүхий 22 төслүүдийг хэрэгжүүлсэн байна.



2023-2024 оны жилд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж байгаа төслийн товч

1. МОНГОЛЫН АНХНЫ ЭХ БАРИГЧ БЭЛТГЭХ ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН УР ЧАДВАРЫН ТӨВ

Монголын анхны Эх барихын яаралтай тусламжийн ур чадварын төвийг байгуулах төсөл маань АНУ-н 6600 дүүргийн Сент Марис Ротари клубтэй хамтран Олон Улсын Ротари Сангаас \$190,000 ам.долларын санхүүжилт авч 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

2. "LET'S READ" буюу "ХАМТДАА УНШИЦГААЯ" НОМ ХАНДИВЛАХ ТӨСӨЛ

"Хамтдаа Уншицгаая" төсөл бол Улаанбаатар хотын захын дүүргийн болон орон нутгийн

алслагдсан, боловсролын хүртээмж муу төв суурин газруудад буй хүүхдүүдэд ном унших дадал зуршлыг нэмэх, номын сантай болгох, зорилгоор анх 2017 онд санаачлагдан эхэлсэн төсөл бөгөөд хот хөдөө, орон нутгийн англи хэлний 50 багш болон 6 номын санд нийт 10 мянга гаруй ном, 24 сургалтын таблет, 160 таблетан ном, 15 проектор, зөөврийн 16 компьютер, ширээний 1 компьютер, 12 кассет болон CD тоглуулагч, 228 тоглоом, 88 сагс болон хөлбөмбөгийн бөмбөг, 41 сонсдог ном, 223 CD-тэй ном, хүүхдийн кинотой 100 видео кассет, 6 дэлхийн бөмбөрцөг болон ангийн самбар зэрэг үнэт зүйлсийг хандивлаад байна.

3. "EMPOWERING YOUNG MIND" – Залуусынхаа сэтгэл зүйг чадавхжуулья

2023-2024 оны Ротари жилд Сэтгэл зүйн эрүүл мэндийг чухалчилж авч үзсэн жилийн хувьд Дүүргийн санхүүжилтээр бидний хэрэгжүүлсэн төсөл бол "Залуусынхаа сэтгэл зүйг чадавхжуулья" төсөл юм. Энэ төслөөр мэргэжлийн сэтгэл зүйч, мэргэжилтнүүдтэй хамтран суралцах, ажиллах орчныг бүрдүүлэх болон нэмэгдүүлэхэд чиглэсэн, захийн хорооллын ерөнхий боловсролын сургуулийн өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийг сайжруулах зорилготой юм. Төсөл маань 2023 оны 10 сард нээлтээ хийж 2024 оны 4 сард амжилттайгаар дуусгаж тайлангаа өгсөн байдаг.



4. "Fight against Live cancer" буюу "ЭЛЭГ ЭМТРЭМ" нөлөөллийн аян

2022 оны байдлаар Монгол улсад 6885 тохиолдлын 1/3 буюу 33,2% нь Элэгний хорт хавдар, нийт хорт хавдараар нас барсан 4548 хүмүүсийн 36% нь элэгний хорт хавдарын шалгаантай байжээ.

Элэгнийхортхавдрийнэсрэгиргэдэгзориулсан нөлөөллийн аяныг манай клубын хүндэт гишүүн Гүрбадмын Үнэнбатын санаачилгаар Залуусын өргөн чөлөө Ротаракт клубын залуусын гүйцэтгэлтэйгээр, Хавдар судлалын Үндэсний төвтэй хамтран 2023 оны 11-12 сард сошил орчинд хийж гүйцэтгэсэн байна.

НАРЛАГ УЛААНБААТАР РОТАРИ КЛУБ



Р.САРАНЧИМЭГ

Нарлаг Улаанбаатар Ротари клубийн 2023-2024 Ерөнхийлөгч

Нарлаг Улаанбаатар Ротари клуб нь идэвхтэй 20 гишүүнтэй, PNF 3, 100% EREY клуб юм. Ротари нэгэн шинэ жилийг нэгэн аравны түүхээ тэмдэглэж дараагийн 10 жилийн үйл хэрэгээ тодорхойлсон сайхан жил боллоо. Хийсэн бүтээсэн төсөл ажлуудаа танилцуулж түүгээрээ бахархаж бусадтай хуваалцсан клубын үүсгэн байгуулагдсан 10 жилийн ойн арга хэмжээгээ 2023 оны 9 сард тэмдэглэн өнгөрүүллээ. Энэ түүхт жилдээ зориулж бид ерөнхийлөгчийн нэрэмжит аялалыг Япон улс руу хийж гишүүдээ идэвхжүүлэх, нөхөрлөлийг батжуулах сайхан дурсамжтай аялалыг клубынхээ түүхэнд бичлээ.

Энэ жил бид бусдад итгэл найдвар авчирах олон сайхан төсөл хийж нийт 2680 хүн цаг зарцуулсан байна. Ротари сангийн глобал грантаар хэрэгжүүлдэг Шинжлэх ухааны лаборатори -3 төслийг амжилттай хэрэгжүүлж нийслэлийн 2 сургууль,

орон нутгийн 3 сургуульд нийт 78000 ам долларын санхүүжилтээр Япон улсын Кобе Сума клубтэй хамтарч лаборатори танхимыг бүрэн тохижуулж 2023 оны 9 сард хүлээлгэн өглөө. Нийт 1000 гаруй сурагч энэхүү дугуйланд хамрагдан суралцаж ирээдүйн инженер, шинжлэх ухаантан болох замналаа хэдийн эхлүүлсэн байна.

- Шинжлэх ухааны лаборатори-3 төслийн үргэлжлэл болгон Япон улсын 2500 дүүргийн VTT – төслийн 15000 ам долларын санхүүжилтаар Шинжлэх ухааны дугуйлан -1,2,3 төслийг хэрэгжүүлсэн 8 сургуулийн багш нараас 5 багшийг шалгаруулж мэргэжлийг дээшлүүлэх, арга зүйд дадлажуулах зорилгоор Япон улсад суралцуулахаар явуулж байна. Сонгол шалгаруулалтыг 2024 оны 2 сарын 24 нд Ротари өдрөөр бүх Ротаричуудын өмнө шалгаруулсан билээ.
- ОУР 3450 Дүүргийн Грантаар ГССҮТ-ийн түлэнхийн төвд хөдөлмөр заслын өрөөг тохижуулж 16 сая төгрөг буюу 4700 ам долларын санхүүжилтаар шаардлагатай тоног төхөөрөмж хэрэгсэл авч өглөө. Энэ төслийн үр дүнд өвчтөнд үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмж 3 дахин нэмэгдэж байна.
- Мөн энэ жил нэгэн шинэ NMUMS Интеракт клубын өлгийдэн авч залуу үеэ бэлтгэж байна. Одоо бид 3 интеракт клубын ээж клуб болсон байна.
- Япон улсаас 2 удаа зочид төлөөлөгч хүлээн авч хамтын ажиллагаа өргөжүүлж ажиллалаа.



НОМТ РОТАРИ КЛУБ



Д.ХИШИГБУЯН

Номт Ротари клубийн 2023-2024 Ерөнхийлөгч

2013 онд байгуулагдсан. Нийт 19 гишүүнтэй.

Дотуур байрны номын сан төсөл:

Төв аймгийн Мөнгөнморьт сумын ЕБС-ийн дэргэдэх дотуур байранд гэрээсээ хол байгаа 60 гаруй хүүхдэд гэртээ байгаа мэт дулаан орчин бүрдүүлж, чөлөөт цагаараа хамтдаа унших хөгжих, түүх соёл, уран зохиол, гадаад хэл судлахад зориулан гарын авлага, хүүхдийн номын дээжис бүхий монгол, англи, япон хэл дээрх 500 номтой “Номын сан” - “Хүүхэд хөгжлийн өрөө”-г 2023 оны 10 сарын 23 нд шинээр тохижуулан бяцхан эздийг нь баярлууллаа. Мөн “Цэцэг гүн” РК-тай хамтран Төв аймгийн Эрдэнэсант сумын ЕБС-ийн номын санг тохижуулж, “Цахим ном уншлагын хэсэг”-ийг компьютер, цахим монгол болон гадаад ном, нийт 200 гаруй ном, 40 гаруй DVD-гээр хангахад дэмжлэг үзүүллээ.



Номын хандивын аян

2023 оны 9 сарын 15-17-ний өдрүүдэд Сүхбаатарын талбайд болсон Номын баяраар хандивын ном цуглуулах кампанит ажил өрнүүлэн, Ротари клубийн найз нөхөд, клубийн гишүүдийн гэр бүл, ажлын хамт олон болон өөрсдөө номоо олон нийтэд таниулан борлуулж буй хэвлэлийн компаниуд, хувь хүмүүс олон олон ном хандивласнаар нийт 500 гаруй номтой болсон. Түүгээрээ сумын сургуулийн номын сангаа тохижуулах юм.

Ирээдүй чиний гарт” менторшип төсөл

Дүүргийн грантавч, “Ирээдүй чиний гарт” менторшип төслийн хүрээнд нийслэлийн БЗД-н 147-р сургууль болон Сонгинохайрхан дүүргийн ЕБС-ийн 12, 62, 143, 153, 154 дүгээр сургуулийн 11, 12- дугаар ангийн 150 гаруй сурагчид сургалт явуулан, клубийн Ерөнхийлөгч “Мөрөөдлийн ажил мэргэжил” номоо хандивлалаа. Дараа нь сурагчдыг сонирхсон мэргэжил, сонирхлоор нь 20-25 гишүүнтэй бүлэг болгон, ирээдүйн ажил мэргэжилтэй нь холбоотой байгууллагатай танилцах аяллыг цувралаар зохион байгуулсан. Монгол банкны Эрдэнэсийн музей Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК, Ус сувгийн удирдах газар, НҮБ-ын Хүүхдийн сангийн үйл ажиллагаатай танилцах аялал зохион байгууллаа.

Клубын 10 жилийн ойн арга хэмжээ

Манай клуб нь үүсгэн байгуулагдсан 10 жилийн ойн арга хэмжээгээ Зорилго үйлс нэгт ротаричуудтайгаа хамт “Танилцъя” нэртэйгээр ёслол төгөлдөр тэмдэглэж 10 жилийн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлаа танилцууллаа.



УЛААНБААТАР ХАНГАРЬД РОТАРИ КЛУБ



А.ДАВААНИМ

**Улаанбаатар Хангарьд Ротари клубийн
2023-2024 Ерөнхийлөгч**

Үүсгэн байгуулагдсан: 2016.01 сар

Улаанбаатар Хангарьд Ротари Клуб нь 2016 оны 1 сард Улаанбаатар Ротари Клубийн дэмжлэгтэйгээр үүсгэн байгуулагдсан Монгол улсын 15 дахь Ротари клуб юм. 2017 оны 1-р сарын 06 нд Олон улсын Ротари Интернэшлд албан ёсоор бүртгэгдэж, Монголын 3450 дүүргийн 9-р бүсэд харьяалагдах болсон билээ.

Одоогоор 15 идэвхтэй гишүүнтэй, хамгийн <залуу> гишүүдтэй клуб юм. Манай гишүүдийн дундаж нас 32 бөгөөд хүйсийн харьцаа эмэгтэй 60%, эрэгтэй 40%.

Бид Ногоон Замнал, Шидэт Тоосго, Water Kiosk, Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд зэрэг төслүүдийг Олон улсын болон Монголын холбогдох байгуулагуудтай хамтран амжилтай хэрэгжүүлж байна.



БАЯНЗҮРХ РОТАРИ КЛУБ



Ж.УРАНБИЛЭГ

Баянзүрх Ротари клубийн 2023-2024 Ерөнхийлөгч

Баянзүрх Ротари Клуб нь 2017 оны 06 сарын 16-ны өдөр Улаанбаатар Ротари Клубын охин клуб болон байгуулагдаж 10 гишүүнтэй 7 жил үйл ажиллагаагаа явуулж байна.

Манай клуб олон улсын Ротари, бүс нутаг, дүүргийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, хувь нэмрээ оруулсаар ирсэн. Бид

Ротаричуудаас суралцаж, хамтран ажиллаж, нийгэмд тогтвортой, урт хугацааны үйлчилгээг үзүүлэх клуб болохын төлөө ажиллаж байна.

Манай клуб хорт хавдартай хүүхэд, тэдний асран хамгаалагчдыг урлагаар эмчлэх төслийг хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд Монголын Хавдрын Үндэсний Зөвлөл ТББ-ын харьяа хөдөө орон нутгаас хот руу зорчиж буй өвчтөнүүд болон тэдний асран хамгаалагчдад зориулсан “Дарь Эх Өргөө” байран дахь урлагын эмчилгээний өрөөг тохижуулсан. Энэхүү төсөл нь 2024 оны 1-р сард эхэлж, 2024 оны 4-р сард хэрэгжиж дууссан бөгөөд энэ хугацаанд 46 өвчтөнд бүлгийн урлагын эмчилгээ, 65 өвчтөн болон тэдний асран хамгаалагчид, тэр дундаа хорт хавдартай хүүхдүүдэд ганцаарчилсан сэтгэл зүйн мийн дэмжлэг үзүүлэх зөвлөгөө өгчээ. Эдгээр үйлчилгээнд хамрагдсан өвчтөн, асран хамгаалагчдын дунд явуулсан санал асуулгын дүнгээс харахад оролцогчдын 95% нь энэ үйлчилгээ нь хүнд хэцүү үеийг даван туулахад тустай, ач холбогдолтой, эерэг нөлөө үзүүлж байгааг илэрхийлжээ.



ТЭНГЭР РОТАРИ КЛУБ



Б.САЙНЖАРГАЛ

Тэнгэр Ротари клубийн 2023-2024 Ерөнхийлөгч

Тэнгэр Ротари клуб нь 2023-2024 оны Ротари жилд бид 30 гишүүнтэйгээр эрүүл мэнд, хүүхдийн хөгжил, боловсрол, байгаль хамгаалал ба нөхөн сэргээх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэн, төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэн, өөрөөсөө давж бусдад туслах уриаг эрхэмлэн ажиллаж байна.

Тархи судасны эмгэгийн мэс заслын эмчилгээ - GG 2454666:

“Мэдрэлийн мэс заслын багаж тоног төхөөрөмжийг сайжруулах, мэс заслын боломжийг нэмэгдүүлэх төсөл” нь манай клубын хэрэгжүүлсэн хамгийн анхны Global Grant төсөл юм. Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг, Хүрээ Ротари клуб, Чонан Досол Ротари клуб,

Чонан Сангрок Ротари клуб, Жинжү Дэбон Ротари клуб, Токио Нерима Уэст Ротари клуб зэрэг байгууллагуудын хамтын оролцоотойгоор уг төслийг хэрэгжүүллээ.

Green Mongolia:

Манай клубээс санаачлан хэрэгжүүлж буй “Green Mongolia” санаачилгын хүрээнд шороон шуурганы эрсдэлийг бууруулах зорилготойгоор Дундговь аймгийн Баянжаргалан суманд 2,000 чацарганы мод тарьж сумын байгал орчны мэргэжилтэнд хүлээлгэн өглөө.

Чингэлтэй хайрхны явган аяллын шинэ зам:

Мөн Чингэлтэй хайрханы Зүрх ууланд орчны үзэмжийг сайжруулж, явган зорчигчдын аюулгүй байдлыг хангах үүднээс Улаанбаатар Тэнгэр Ротари клуб нь байгалийн ландшафттай зохицсон явган аялал, дугуйн шинэ маршрутыг бий болголоо

Томьёо Интеракт клуб:

Тэнгэр Ротари клубын 5 жилийн ойн хүрээнд бид дараа үеийн Дэлхийн иргэнийг бэлтгэх зорилготой бөгөөд “TomYo School of Ulaanbaatar”-тай хамтран анхны Томьёо Интеракт клубээ 2024 оны Зургаадугаар сарын 10-ны өдөр ОУ-ын Ротари байгууллагаар баталгаажуулан гэрчилгээгээ гардан авсан баярт үйл явдал тохиолоо.



МӨРӨН ХҮРЭЭ РОТАРИ КЛУБ



Н.СЭРЖМЯТАВ

**Мөрөн хүрээ Ротари клубийн 2023-2024
Ерөнхийлөгч**

Мөрөн Хүрээ Ротари клуб нь Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулдаг 23 ивэвхтэй Монгол, Солонгос гишүүдтэй клуб юм. 2023 оны 11 сарын 11-ний өдөр Олон Улсын Ротарийн Ерөнхийлөгчийн Монгол улсад хийсэн айлчлалын үеэр гэрчилгээ гардан авсан ба Хөвсгөл аймагт нийгмийн хэрэгцээт хэд хэдэн төслүүдийг эхлүүлээд байгаа юм.



ШИНЭ ГҮҮР РОТАРИ КЛУБ



Б. ЖАВХЛАН

**Шинэ гүүр Ротари клубийн 2023-2024
Ерөнхийлөгч**

Сертификат огноо: 2023.11.09

Уулзалтын өдөр: Пүрэв гаригт 19:00 цагаас

Үүсгэн байгуулагч зөвлөх: ПАГ Кермен Норпэл,
ПАГ Гурбадамын Цэрэнчимэг

Гишүүдийн тоо: 19

Клубын үйл ажиллагаа:

1. Хан-Уул дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав - 2024.03.24
2. Улсан Дунжи Ротари клубтэй эгч, дүү клубийн санамж бичиг байгуулав - 2024.03.29

Төслүүд:

1. Нярайн хөргөөх аппаратны төсөл
2. Нярайн дотор эрхтний өвчлөлийн эрт илрүүлгийн төсөл
3. Асаргааны төсөл
4. Анхны тусламжийн чадавх олгох төсөл



ХАНГАЙ РОТАРИ КЛУБ



Б.ЭРДЭНЭБУЛГАН

Хангай Ротари клубийн 2023-2024 Ерөнхийлөгч

Хангай Ротари Клуб нь клубын үндсэн гишүүдийн Булган нэг үе клуб ТББ-ын дор нэгдсэн олон жилийн нөхөрлөл, хамтын ажиллагаа, Хавдаргүй Булган, Хүүхдийн тэргэнцэр зэрэг томоохон төслүүдийг хамтран хэрэгжүүлсэн туршлага дээр суурилан байгуулагдсан.

Бид 2022 оноос шинэ клуб байгуулах үйл явцыг эхлүүлж, Ротари сургалтууд, түүний дотор Үүсгэн байгуулагч ерөнхийлөгчийн академид хамрагдсан. 2024 оны 1-р сарын 13-нд болсон зохион байгуулалтын анхны хурлаар клубын удирдлагуудыг сонгосон.

ТӨСЛҮҮД

Хүүхдийн тэргэнцэр төсөл

Бид Австралийн Самнер Парк Ротари клубтэй хамтран Хүүхдийн тэргэнцэр төслийг хэрэгжүүлж байна. 2023 оны арваннэгдүгээр сард бид нэг контейнер буюу 154 тэргэнцэр хүлээн авч, Улаанбаатар, Орхон, Дархан, Хөвсгөл зэрэг аймгуудын тусгай хэрэгцээтэй 90 гаруй хүүхдүүдэд тараагаад байна.

Өсвөр насныхны амьдралын дасгалжуулагч төсөл

Бид өсвөр үеийнхний сэтгэл зүйн эрүүл мэнд, бэлгийн боловсролыг дэмжих зорилгоор JCI Монгол байгууллагатай хамтарсан энэхүү төслийг хэрэгжүүлж байна. Эхний шатны сургалтыг 2024 оны 4-р сарын 27-29-ний өдрүүдэд зохион байгуулж, 60 өсвөр насны сургагч багшийг бэлтгэсэн ба тэдгээр хүүхдүүд маань өөр өөрсдийн сургуульдаа мэдлэгээ түгээж байна.

Эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийн магадлан шинжилгээ төсөл

Бид 2024 оны 4-р сарын 24-ний өдөр Улсын хоёрдугаар эмнэлэгт эрүүл мэндийн салбарын ажилтнуудын дунд Хүний эрхийн магадлан шинжилгээ хийх анхны санаачлагыг эхлүүлээд байна.





ОЛОН УЛСЫН РОТАРИЙН 3450 ДҮҮРГИЙН 10-Р БҮСИЙН РОТАРИ КЛУБУУД



ХҮРЭЭ РОТАРИ КЛУБ



Т.АМАРТУВШИН

Хүрээ Ротари клубийн 2023-2024 Ерөнхийлөгч

Байгуулагдсан огноо: 2002.02.28

Гишүүн: 36 (эмэгтэй-23, эрэгтэй-13)

PAUL HARRIS FELLOW CLUB: 100%

Мажор донор: 9

Эгч дүү клуб: 2 /Cheonan-Dosol RC, RID 3620, Geoje Big Dragon RC, RID 3590/



Орон нутгийн номын сангийн төсөл

Төв аймгийн Баянчандман сум, Эрдэнэсант сум, Зуун мод хот, Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд 100сая төгрөгний үнийн дүн бүхий 4номын санг дотоод болон гадаадын ротари, ротаракт клубууд болон хувь хүн, аж ахуй нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлсэн. Үр дүнг нийт 12000 сурагч хүртэж байна.

GG номын сангийн төсөл

Япон улсын 18 ротаракт клуб болон Монгол улсын 4 ротаракт клубтэй хамтарч 32000\$ үнийн дүн бүхий 2 номын сангийн төслийг 86,79-р сургууль дээр хэрэгжүүлсэн. Тус төсөл нь дэлхийн хамгийн анхны ротаракт клуб хэрэгжүүлсэн GG төслөөр шалгарсан. Үр дүнг нийт 6000 сурагч хүртэж байна.

Мэдрэлийн мэс заслын багаж хэрэгсэл хандивлах төсөл

Улсын 2-р хэмнэлэгт 86000\$ үнийн дүн бүхий төслийг Япон, Солонгос улсын ротари клубууд болон Тэнгэр ротари клубтэй хамтарч GG-р хэрэгжүүлсэн.

Үр дүнг зүүн болон төвийн бүсийн өвчтнүүд даатгааар дамжуулан хүртэнэ.



ЗУУНМОД РОТАРИ КЛУБ



Д.БАЯРБАТ

Зуунмод Ротари клубийн 2023-2024 Ерөнхийлөгч

Зуунмод Ротари клуб нь 2003 оны 7-р сарын 18 ны өдөр анх удаа орон нутагт байгуулагдаж Олон Улсын батламжаа хүлээн авсан.

2023-2024 оны Ротарийн жилд Зуунмод клуб 17 гишүүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Зуунмод Ротари клуб нь дэргэдээ Ротариг дэмжигчдийн бүлэг болон Зуунмод Интеракт клуб байгуулан ажиллаж байна.

2023-2024 оны Ротарийн жилд Зуунмод Ротари клубын нэрийн төсөл болох “Зуунмод100 хүүхэд” төсөл ОУР-ын 3450 Дүүргийн хэмжээнд “ШИЛДЭГ 10” төслийн нэгээр шалгарсан.

Зуунмод Ротари клуб нь Дүүргийн төсөлд орон нутгийн 2 сургуульд “Сурагчдын сэтгэцийн эрүүл мэндийн байдлын судалгаа, сургалтын чиглэлээр оролцож амжилттай хэрэгжүүллээ.

Зуунмод Интеракт клубын Интерактууд Дүүргийн хэмжээнд анх удаа зохион байгуулсан 3х3 сагсан бөмбөгийн 2 шатны тэмцээнд тэргүүн байр эзэлж Цом, Аваргын алтан медаль хүртлээ



НИЙСЛЭЛ РОТАРИ КЛУБ



Т.УРАНЧИМЭГ

Нийслэл Ротари клубийн 2023-2024 Ерөнхийлөгч

Монгол Улсад Ротари хөдөлгөөнийг дэлгэрүүлэн хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан ууган клубуудын нэг Нийслэл Ротари клуб нь 21 жилийн өмнө буюу 2003 оны 07-р сарын 18-ны өдөр байгуулагдсан түүхтэй. Өнөөдөр тус клуб нь өөрөөсөө давж бусдад үйлчлэх, нийгмийн сайн сайханд хувь нэмрээ оруулах чин хүсэлтэй 31 гишүүнтэй тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

Нийслэл ротари клуб нь Солонгос, Япон, Тайваны эгч дүү клубуудтэйгээ хамтран хүмүүнлэгийн төслүүдийг хэрэгжүүлэхээс гадна Монголын болон Хонгконг, АНУ-ын ротари клубуудээс хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдийг дэмжин оролцдог. Нийслэл Ротари клуб 2023-2024 онд “Өөрөөсөө давж бусдад туслая” ротарийн уриан дор нийгмийн сайн сайхны төлөөх 2 шинэ төслийг эхлүүлж, 2 төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд бэлтгэл ажлыг нь хангаж байгаа 2 төсөлтэй байна. Тухайлбал, 2023-2024 онд Нийслэл Ротари клуб нь 2003 оноос хойш эгч дүүсийн харилцаатай байгаа БНСУ-ын Ён-Ин Ротари Клуб (ОУР-ийн 3600 дүүрэг)-тэй хамтран Улаанбаатар хотын 165 дугаар бага сургуульд номын сан байгуулах төслийг хэрэгжүүлсэнээс гадна харилцан айлчлал хийж, хамтын ажиллагаагаа бататган цаашид хамран хэрэгжүүлэх төслүүдээ батлаад байна.

Мөн 2004 оноос хойш ихэр клубын харилцаатай байгаа Тайванийн Тайпэй Сан Янг Ротари Клуб (ОУР-ийн 3840 дүүрэг)-тэй дараагийн 5 жилийн хамтын ажиллагааны гэрээг байгуулах, хамтран ажиллах чиглэлээ тодорхойлох бэлтгэл ажлаа эхлүүлээд байна.

2023-2024 онд хэрэгжүүлж байгаа төслүүдээс дурьдвал:

Нярайн тандалт, эрт илрүүлгийн төсөл:

“Нийслэл Ротари клубын нэрэмжит төсөл” болох энэхүү төслийн хүрээнд Нярайн тандалтын шинжилгээний ажлыг 2012 оноос эхлүүлж 2016-2017, 2019-2020, 2022 онуудад ОУР-ийн санхүүжилт дэмжлэгтэйгээр нярайн тандалтын шинжилгээг хоёр төрлөөр нэмэгдүүлсэн юм. Өдгөө 8 дахь жилдээ Улаанбаатар хотод болон 3 аймагт хэрэгжиж байна. Төслийг Нийслэл Ротари клубын гишүүн, РР Г.Эрдэнэтуяа санаачлан өнөөг хүртэл амжилттай удирдан хэрэгжүүлж байна.

Улаанбаатар хотын 165 дугаар бага сургуульд номын сан байгуулах төсөл:

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн алслагдсан хорооны бага сургуульд номын сан байгуулж, хүүхдүүд номонд дуртай болох, чөлөөт цагаараа номын санд ном унших, хичээлээ давтах, хичээлийн дараа гэр бүлийнхэн нь сургуулиас авах хүртэл тухтай, дулаахан өрөөнд амрах боломжийг бүрдүүлсэнээс гадна сургуулийн багш нарт чөлөөт хэлбэрээр хичээл заах боломжтой болсон.

Хан-уул дүүргийн 209-р цэцэргэлийн спорт

өрөөний засварын төсөл: - 2023 оны үерийн уснаас барилгын суурьт суулт өгч, бүрэн эвдрэл үүссэн Хан-Уул дүүргийн 100 хүүхдийн суудалтай 209 дүгээр цэцэрлэгийн спорт өрөөг засварлаж, хүүхэд багачууд жилийн сургалтын хугацаандаа спортоор хичээллэх боломжийг бүрдүүлсэн.

Нийслэл Ротари клуб нь төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээс гадна гишүүдээ хөгжүүлэх, багаар ажиллахад дэмжлэг үзүүлэх, залуу үеэ бэлтгэхэд онцгой анхаардаг. Тус клуб нь Хобби ротаракт клуб болон 3-н интеракт клубуудын ээж клуб юм.



ТУУЛ РОТАРИ КЛУБ



П. ГАНТУЛГА

Туул Ротари клубийн 2023-2024 Ерөнхийлөгч

Монгол улсдаа тав дахь клуб олон мэндэлсэн.

Гурван охин клубууд төрүүлсэн /Гурвансайхан, Тамир болон Хүннү

2005 оноос Зүрх төсөл амжилттай хэрэгжүүлсээр ирсэн ба 2015-2018 онуудад “Хүүхдийн зүрхний мэс заслын тусламжийг чадавхижуулах” Global grant 1415791 төслийн хүрээнд Сөүлийн их сургуулийн эмнэлгийн 26 эмч, сувилагч, судлаач нарын баг энэ удаад ирж төрөлхийн зүрхний гажиг өвчтэй хүүхдүүдийн хамгийн эрсдэлтэй

тохиолдолын хүнд хагалгааг Монголдоо хийж 8 бяцхан зүрхэнд амьдрал бэлэглэсэн. Зүрх төслийн хүрээнд нийт 350 хүүхдэд тусалсан юм.

“НЭР ТӨРӨӨ ЭРХЭМЛЭХ ӨДӨР” Туул Ротари клуб Туул 2013 оноос “Даян Дэлхийн Нэр Төрөө Эрхэмлэх Өдөр”-ийг тохиолдуулан Монгол Улсын ирээдүй болсон ЕБС-ийн сурагчид болон оюутнуудыг хамруулсан лекцийг жил бүр ротариктуудтайгаа хамтран зохион байгуулдаг.

БНСУ-ын Почень Эоуллим клубтэй хамтран ажилладаг ба өнгөрсөн жил боломжгүй айлын хүүхдүүдэд өвлийн хувцас хандивласан.

Туул Интаракт клубээ 2023 онд үүсгэн байгуулсан.



СЭЛБЭ РОТАРИ КЛУБ



Г. ЭНХТУЯА



Сэлбэ Ротари клубийн 2023-2024
Ерөнхийлөгч



Миний Увс is with Улаангом Хураа and 17 others
February 21

Сэлбэ Ротари клуб GG2124721 төслөө Улаанбаатар Ротари, Солонгосын Сэбу Ротари Клубтай хамтран Корид 19 цар тахалтай тэмцэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Увс аймгийн ахлагдсан 6 сумдын эмнэлэг болон Нэгдсэн эмнэлэг нийт 30 гаруй сая Төгрөгийн өртөг бүхий худалд орлого өггөрүүлж, өмчлөлийн хяналтын зөөврийн мониторинг хөдөлгөөлөө Ротарийн төсөл үргэлжлэж байна.



ТАМИР РОТАРИ КЛУБ



Т. МӨНХБАЯР

Тамир Ротари клубийн 2023-2024 Ерөнхийлөгч

Дэлхийн Ротарийн гэр бүлийн гишүүн Тамир Ротари клуб нь 2009 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр Монгол улсын 8 дахь ротари клуб болон үүсэн байгуулагдсан.

Тамир ротари клуб нь нийт 16 гишүүнтэй, Үүнээс 4 гишүүн - Honorary membership

Энэ жил манай клубын 15 жилийн ой болж өнгөрлөө. Бид олон улсын Ротари байгууллагаас гаргасан уриалга, үндсэн чиглэлийн хүрээнд өнгөрсөн 15 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн зарим нэг төсөл хөтөлбөрийг дурдвал:

- 5440 дүүргийн АНУ-ын Стар вале ротари клуб, 5450 дүүргийн Eclub one rotary клубтэй хамтран “Нярайн хүүхдийн хувцас, хэрэглэл, хүчилтөрөгчийн аппарат, амьсгалах төхөөрөмж, шинээр төрсөн хүүхдийн анхны тусламжийн тоног төхөөрөмжийг УБ хотын 1, 2, 3-р төрхүүд, Дархан, Эрдэнэт, Хөвсгөл аймгуудын эмнэлэг, төрөх тасгуудыг хангаж, эмч, сувилагчдад сургалт явуулсан”. Энэхүү төслийн хүрээнд 117 эмч сувилагч сургалтад оролцсон
- 3730 дүүргийн Солонгос улсын Вёонжу-Жунганг Ротари клубтэй хамтарсан (Matching Grant #74953) төслийн хүрээнд Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний төвийн Цусны эмгэг судлалын тасагт эмчлүүлж буй цусны цагаан эсийн хорт хавдартай 60 гаруй хүүхдүүдэд гол хэрэгцээтэй, Монголд үйлдвэрлэгддэггүй нийт 8 төрлийн эм ханган нийлүүлсэн. Үнэ өртөг өндөртэй, эмчилгээний хугацаа 1-3 жил эмнэлэгт хэвтэн эмчлүүлдэг, эдгээр хүүхдүүдэд байнга очиж бэлэг өгч, ярилцаж, тэдний өвчин зовлонг бага ч болтугай хуваалцаж байсан хүмүүнлэг төслийг Тамир Ротари клуб хэрэгжүүлсэн.
- Мөн төрийн ордонд “Хүүхдийн сэтгэлд хүрэх хамгийн дөт зам” сэдэвт 1000 хүүхдийн арга хэмжээг 2 жил дараалан зохион байгуулсан, хотын худалдааны төвүүдэд ажилладаг эцэг эхчүүдэд

зориулж “Мэдлэгт суурилсан эдийн засаг” илтгэл, арга хэмжээг Төрийн ордонд зохион байгуулсан.

- Хонконгийн Сохо ротари клубтэй хамтран “Нийгмийн стрессийн менежмент”, Сэтгэл зүйчдэд зориулсан мэргэжлийн сургалтууд, Эрүүл мэндийн хүрээлэн, өрхийн эмнэлгийн ажилтнуудад зориулсан сургалт, Цагдаа, хүчний байгууллага, Их сургуулийн багш нарт зориулсан ахисан төвшний чадавхжуулах сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулсан билээ.

Бид клубийнхээ 10 жилийн ойн хүрээндээ 2019 онд “АМЬДРАЛ БЭЛЭГЛЭЭ” төслийг Япон улсын Мацудо-Ниши Ротари клуб болон Улсын Нэгдүгээр төв эмнэлгийн Цусны эмгэг судлал, чөмөг шилжүүлэн суулгах төвтэй хамтран хэрэгжүүлж Цусны үүдэл эс шилжүүлэн суулгах өвчтөний хагалгааны зардлыг санхүүжүүлсэн.

Монгол улсад энэ төрлийн хагалгаа хийлгэхэд хагалгааны зардлын 10 хувийг эмчлүүлэгч өөрөө төлдөг юм. Манай клуб “АМЬДРАЛ БЭЛЭГЛЭЭ” төслийн хүрээнд 2019 онд 2, 2020 онд 2 нийт 4 эмчлүүлэгчид санхүүжилт олгоод байна.

2023-2024 оны Ротарийн жил, мөн клубын 15 жилийн ойн хүрээндээ бид дараах 2 төслийг амжилттай хэрэгжүүлж дуусгалаа.

- Хүүхдийн цэцэрлэгийн “Гүний худаг” төслийг Олон Улсын Ротарийн 2790 дүүргийн Мацудониши ротари клубтай хамтран хэрэгжүүлж 2023.09.09 өдөр төслийн нээлтээ хийсэн. Нийслэлийн Налайх дүүргийн 152 дугаар цэцэрлэг дээр төслөө хэрэгжүүлснээр иж бүрэн гүний худагтай болгож 380 гаруй хүүхдийн ундны усны чанарыг сайжруулав чадсан.
- Улсын Хоёрдугаар Төв Эмнэлгийн хавдрын химийн эмчилгээний тасгийн өдрийн эмчилгээний танхимыг тохижуулав.

Бид бусдад амьдрал, аз жаргал бэлэглэх болно. Та бүхнийг бидний үйл ажиллагаа, төсөл хөтөлбөр бүхэнтэй, хамт байгаарай гэж чин сэтгэлээсээ хүсэж байна.



СЭЛЭНГЭ РОТАРИ КЛУБ



Ц.ЭРДЭНЭЧИМЭГ

Сэлэнгэ Ротари клубийн 2023-2024 Ерөнхийлөгч

Сэлэнгэ Ротари клуб нь Сэлэнгэ аймгийн Засаг даргаар ажиллаж байсан Содын Бүрэнбат санаачлаг гаргаж салбар бүрийн төлөөлөөс бүрдсэн хүмүүсийг цуглуулан 2014 онд үйл ажиллагаагаа эхлүүлж, 2015 оны 5 сард Монголын Ротари хөдөлгөөн үүссэний 20 жилийн ойгоор Ротари интернейшнл хэмээх том айлын ам бүлд нэгдсэн. Тэр үеэс хойш нийт 32 гишүүнийг эгнээндээ нэгтгэн бусдын сайн сайхны төлөө хамтын нөхөрлөлийн суурин дээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн.

Өнгөрсөн 9 жилийн хугацаанд клубийн Ерөнхийлөгчид болон гишүүдийн идэвх санаачлаагаар нэлээд хэдэн төслийг хэрэгжүүлж, бусдын сайн сайхны төлөө цаг зав, хөрөнгө зарцуулсан.

Төслүүд, спортын тэмцээн, 5 жилийн ойн арга хэмжээ, БНСУ-ын Ротари клубүүдтэй хамтран ажилласан ажиллагаанд гишүүд маш идэвхтэй оролцсон. Гишүүн Мөнгөнзаяа маань үгийг нь бичсэн сүлд дуутай ч болсон.

Хэрэгжүүлсэн төслүүд:

1. “Ус цэвэршүүлэгч” төслийг БНСУ-ын Даннару Ротари клубтэй хамтран Сүхбаатар сум, Хүдэр, Баянгол, Хушаат сумдын ерөнхий боловсролын сургуулиудад ус цэвэршүүлэх аппаратыг суурилуулж, сурагчдын ундны усны хэрэгцээг хангаж чадсан билээ.
2. Аймгийнхаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зориулалтын тэргэнцэртэй болгохоор “Тэргэнцэр” төслийг АНУ-ын Оакдель Ротари клубтэй хамтран хэрэгжүүлсэн. Оакдель Ротари клубээс төсөлд зориулан Сэлэнгэд хүрэлцэн ирж гардуулж өгсөн 32 хүн тус бүрд тэргэнцрийг нь тохируулан угсарч өгсөн билээ.
3. Харааны бэрхшээлтэй хүүхдүүдийн оношилгоо эмчилгээ
4. Цэцэрлэгийн хүүхдүүдэд тоглоом, ном
5. Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэгт татлагын ор
6. Эх нярайн эмчилгээ оношилгооны аппарат
7. Үдийн цайны аяга таваг ариутгагч
8. Мандал сумын нэгдсэн эмнэлэгт түргэн тусламжийн автомашин
9. Мандал сумын нэгдсэн эмнэлэгт эмнэлгийн гаралтай хог хаягдлыг ариутгах аппарат
10. Ковидын үед хамгаалах хувцас хэрэгсэл, тоног төхөөрөмж
11. Дулаан хувцас бэлэглэх аян
12. Сумдын сургуулиудад сургалтын хөгжим
13. Сүхбаатар сумын хөл бөмбөгийн багт хувцас, спортын хэрэгсэл зэрэг төслүүдийг амжилттай хэрэгжүүлсэн.



УЛААНБААТАР ЦЕНТРАЛ РОТАРИ КЛУБ



Ц.ЭРДЭНЭБИЛЭГ

**Улаанбаатар Централ Ротари клубийн
2023-2024 Ерөнхийлөгч**


Нийт 27 гишүүнтэй, үүнээс 13 эмэгтэй, 14 эрэгтэй,

Үндсэн нэрийн төслүүд: Test for Life, Ger 4 Life, Horse for Life

- Төсөлд хамрагдсан гишүүдийн тоо: 22
- Дүүргийн конференц оролцсон гишүүд: 2
- Дүүргийн сургалтанд: 6
- 100% Erey клуб

2023-2024 онд хэрэгжүүлсэн төслүүд

- TEST for LIFE – 2005 оноос хэрэгжиж байгаа. “Хавдаргүй Монголын эмэгтэйчүүд” уриатай, умайн хүзүүн хавдрыг эрт илрүүлэх ХО суурилсан шинжилгээ.
- GER FOR LIFE – 2017 оноос хэрэгжиж байгаа: 2023/2024 оноос GG өргөдөл өгөх бэлтгэл хангагдаж байна, Монголоос Гэрэгэ, Зуун мод, Италиас 6 клуб, Хонконгоос 28 клуб, Макао 1 клуб хандив өргөж хамтарч ажиллахаа тохирсон.
- HORSE FOR LIFE – 2023 хэрэгжиж эхэлж байгаа: Төсөлд 10-14 насны нийт арван хүүхэд оролцсон. Хүүхдүүдийн ихэнх нь гэр бүл салалтаас үүдэлтэй сэтгэлзүйн гэмтэлтэй, дэлгэцийн хамааралтай хүүхдүүд байсан. Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш гурван сарын хугацаанд долоо хоног бүр хүүхдүүдийг цэвэр агаарт гаргаж өөрийн гэсэн морьтой болж морио хэрхэн халамжлах, харьцах болон морь унуулж байгаад сэтгэлзүйн эмчилгээ хийлгэсэн. Төслийн хүрээнд нийт гурван сэтгэл зүйч ажилласан.



ГЭРЭГЭ РОТАРИ КЛУБ



Э. АНУДАРЬ

Гэрэгэ Ротари клубийн 2023-2024 Ерөнхийлөгч

Гэрэгэ Ротари клуб нь 2021 оны 4-р сарын 26-нд 21 гишүүнтэй байгуулагдсан.

2023-2024 оны Ротарийн жилд бид 21 идэвхтэй гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн 115-р сургуулийн Интеракт клубийг ивээн тэтгэсэн.

Манай клубын алсын хараа нь “Бид олон талт хамтын ажиллагаагаар дэлхий дахинд нөлөөллийг бий болгох Ротаричуудын тэргүүлэгч шинэ үе байх болно”.



Бидний төслүүд

Murray Bridge RSL-ийн Ротари клубтэй хамтран хэрэгжүүлсэн “Австралийн тоглоомын талбай” төсөл

Murray Bridge RSL Rotary Club, Veloo Foundation-тай хамтран Улаанчулуутын хогийн цэг болон бусад Завхан болон Төв аймгуудад нийт 3 тоглоомын талбайг тохижуулсан.

Төсөв: 50,000 доллар

Equal happiness төсөл

Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орчинд амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн амьдралын чанарыг сайжруулах, шаардлагатай асаргаа сувилгаа, хөдөлгөөнт хэрэгслээр хангах, цаашид хөдөлгөөнийг нь үргэлжлүүлэх боломжоор хангах.

Нийт төслийн үр шим хүртэгсэд 70-90, 50 гаруй сайн дурын ажилтнууд оролцсон

Төсөв: 2,610 ам.доллар

Тайваний Тайпэй Метро Ийст Ротари клубтэй хамтарсан “Мод тарих” төсөл

Гол зорилго нь хайлаас, чацаргана мод тарихад зориулсан эко сав технологийг ашиглан Монгол орны цөлжилтийг сааруулах явдал юм.

Төсөв: 82,400 ам.доллар

Цэцээ Гүнгийн Ротаракт клубтэй хамтарсан “Лабдоо” төсөл

LABDOO төсөл нь хүүхэд залуучуудын боловсролд хөрөнгө оруулахад шаардлагатай зөөврийн компьютер, таблет болон бусад төхөөрөмжүүдийг нийлүүлдэг дэлхийн хүмүүнлэгийн сүлжээ юм. Төслийн хүрээнд бид аймгийн төвөөс тусгаарлагдсан, компьютергүй, мэдээллийн технологийн кабинетгүй сургуульд суралцаж буй хүүхдүүдэд өөрийгөө хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэхийг зорьж байна.

Улаанбаатар Централ Ротари клубтэй хамтарсан “Ger for Life” төсөл

Байнгын эмнэлгийн тусламж авах шаардлагатай хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй, бие бялдрын хүнд өвчтэй 10-15 өрхөд зориулагдсан. Эдгээр гэр бүлийн гишүүдийг 2 жилийн хугацаанд амьдрах орчин нөхцөлөөр хангаад зогсохгүй олон талт сургалтад хамруулж нийгэмд бие даан амьдрах, орлогын эх үүсвэртэй болох, бизнес эрхлэх боломжийг олгох зорилготой юм.

Төсөв: 180,000 доллар

ГУРВАН САЙХАН РОТАРИ КЛУБ



Ч. ЖАРГАЛСАЙХАН

*Гурван сайхан Ротари клубийн 2023-2024
Ерөнхийлөгч*



ХҮННУ РОТАРИ КЛУБ



Э. ГАНБАТ

Хүннү Ротари клубийн 2023-2024 Ерөнхийлөгч

2023.11.11нд Олон Улсын Ерөнхийлөгч Гордон Макнелли Монгол улсад айлчлах үеээр Олон Улсын гэрчилгээгээ гардуулан авсан. Нийт 22 гишүүдийн хамт үүсгэн байгуулагдсан клуб юум. Бид шинээр үүсгэн байгуулагдсан клуб тул клубийн дотоод уур амьсгал, Ротарийг таниулах үйл ажиллагаа ихээр зохион байгуулдаг юм. Бид 3662 Дүүргийн Жэжү арлын Ханлим Ротари клубтэй хамтын ажилагааны гэрээ байгуулж эхний төслүүдээ хэрэгжүүлээд эхэлсэн билээ.



Бид Ханлим Ротари клубтэй хамтран Улаанбаатар хотын, Сүхбаатар дүүргийн 166 болон 171 улсын цэцэрлэгүүдэд хүүхдийн тоглоом болон хэргэцээт зүйлс хандивлаж эхний төслөө эхлүүлсэн байгаа



Rotaract Clubs of Mongolia



ОЛОН УЛСЫН РОТАРИЙН 3450 ДҮҮРГИЙН 9,10-Р БҮСИЙН РОТАРАКТ КЛУБУУД



УЛААНБААТАР РОТАРАКТ КЛУБ КЛУБ



У. БААСАНЖАРГАЛ

Улаанбаатар Ротаракт клубийн
Ерөнхийлөгч

Улаанбаатар Ротаракт клуб

Гишүүд: 30

Хэрэгжүүлсэн төсөл:

“Eye see” төсөл

Тус төсөл нь 17 дох жилдээ хэрэгжиж байгаа бөгөөд энэ жил 180 хүүхдүүдийн хараанд үзлэг хийн, 25 хүүхдэд шил зүүх шаардлагатайг тайлбарлан, өөрт нь тохирсон шилийг өгөн, амжилттай хэрэгжүүлж дууссан.

“Lead me” mentorship төсөл

Тус төсөл нь 3 дах удаагаа хэрэгжиж байгаа бөгөөд төгсөх ангийн эсвэл 11-р ангийн хүүхдүүдэд мэргэжилт сонголт болон удаан ажиллаж буй ажлын байран дээр гарсан мэргэжилтнүүдтэй холбон, зөвлөгөө болон туршлага солилцуулдаг төсөл юм.

“Latin Dance Night” санхүүжилт босгох үйл ажиллагаа

“Eye see” төслийн санхүүжилт босгодог хамгийн гол арга хэмжээ болох “Latin Dance Night” 2023 оны 10 сарын 7-ны өдөр амжилттай зохион байгуулагдаж, амжилттайгаар санхүүжилтээ босгов.



ХҮРЭЭ РОТАРАКТ КЛУБ КЛУБ



Б. АРИУНТУЯА

**Хүрээ Ротаракт клубийн
Ерөнхийлөгч**

Гишүүд: 19

Хүрээ Ротаракт клуб нь энэ жил үйл ажиллагаагаа тогтвортой явуулах дээр илүү анхаарч, олон нийтийг хамарсан төсөл болон олон нийтийн дунд үйл ажиллагаа зохион байгууллаагүй болно.



МУИС-ЫН РОТАРАКТ КЛУБ КЛУБ



Ч.ОЮУНТУЛХҮҮР

**Монгол Улсын Их Сургуулийн
Ротаракт клубийн Ерөнхийлөгч**

Гишүүд: 18

Монгол Улсын Их Сургуулийн Ротаракт клуб нь их сургууль дээ суурилсан анхны Ротаракт клуб бөгөөд энэ жил "Даалуу ажиллагаа" үйл ажиллагаагаа 2023 оны 5 сарын 18-нд амжилттай зохион байгуулав



Rotaract
Clubs of Mongolia



ТУУЛ РОТАРАКТ КЛУБ КЛУБ



Б.ГҮНБИЛГҮҮН

Туул Ротаракт клубийн
Ерөнхийлөгч

Гишүүд: 39

Туул Ротаракт клуб бүх Ротаракт клубүүдийн дундах Сагсан бөмбөгийн тэмцээнийг энэ жил зохион байгуулсан



СЭЛБЭ РОТАРАКТ КЛУБ КЛУБ



О. ЦЭНДБАЯР

Сэлбэ Ротаракт клубийн
Ерөнхийлөгч

Гишүүд: 22

Сэлбэ Ротаракт клуб энэ жил клубийн дотоод тогтвортой байдалд илүү анхаарч, ямар нэгэн төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж, зохион байгуулаагүй.



МОНГОЛЫН РОТАРАКТ КЛУБУУДИЙН ДУНДАХ САГСАН БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭН
1-Р БАЙР
2023.11.25



ЦЭЦЭЭ ГҮН РОТАРАКТ КЛУБ КЛУБ



Т.СОЛОНГО

**Цэцээ гүн Ротаракт клубийн
Ерөнхийлөгч**

Гишүүд: 46

Хэрэгжүүлсэн төслүүд:

Менторшип

8 салбарын хүрээнд Гадаад, Монгол нийт 16 ментортойгоор нийт 20 оюутан шалгаруулан 1 сарын хугацаанд ментор болон зохион байгуулалтын баг харгалзах сургалт хөтөлбөрийг орж тэдгээрээс хоёр шилдэг оюутанд хагас жилийн их сургуулийн төлбөрийг тэтгэлгийг амжилттай олгосон.

**CAREBOX – ҮЕРИЙН ГАМШГИЙН
ТУСЛАМЖИЙН ТӨСӨЛ**

Цэцээ Гүн Ротаракт клубээс 18 дахь удаагаа зохион байгуулж байгаа CAREBOX төсөл хандиваар цуглуулсан зүйлсээ хэрэгтэй хүнд нь хүргэсэн. Энэ удаа бид Улаанбаатар хотод гарсан үерийн гамшигт өртөн, сурах эрхээ эдэлж чадахгүй байгаа хүүхдүүдэд туслахыг зорьсон. Үерийн гарз хохирлыг очиж харсан бид тусламжаа хичээл зүтгэл гарган олон олон сайн санаат хүмүүсийн дэмжлэгийг цуглуулж, өнөөдөр хүлээлгэн өглөө.

Хамтран ажилласан байгууллага: АПУ, Монос Фарм Трейд, Сайн Электроникс, Скайтел, Лайм

“Ном төсөл”

Цэцээ гүн Ротаракт клуб уламжлалт Номын төслөө илүү өргөн хүрээнд хэрэгжүүлж, 7-р сарын 21-нд Эрдэнэсант сумын сургууль дээр “Цахим уншлагын булан”-ыг, 7-р сарын 21-нд Зуунмод сумын ЕБС-ийг тохижуулах зэрэг 3 тусдаа дэд төслийг хэрэгжүүлэхээр зорьсон. Гурав дахь дэд төсөл нь Баянчандмань сумын ЕБС-ийн тохижилтын “Хүүхэд хөгжлийн төвийн хамтарсан төсөл”-ийг 01 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгууллаа. Эдгээр төслийн хүрээнд Хүрээ Ротари клуб, Номт Ротари клуб, Монголын Ротари Ёнеяма төгсөгчдийн холбоо, Мураками Ротари клуб, Ротари зэрэг байгууллагууд хамтран ажиллав. Muraki lawfune клуб, Улаанбаатар Энхтайвны өргөн чөлөөний Ротари клуб, Залуучуудын өргөн чөлөөний Ротаракт клуб зэрэг клубүүдтэй хамтран ажилласан.

Мөн Японы Осака Ийст Ротаракт, Хүрээ Ротари клуб болон Хүрээ Ротаракт клуб, Залуучуудын өргөн чөлөө Ротаракт клуб, Найрамдал Ротаракт клубүүдтэй хамтран Нийслэлийн 79,87-р сургуулиуд дээр 32,800 ам долларын санхүүжилттэй номын сангийн төсөлд хамтран ажиллаа.

Labdoo

Хөдөө орон нутгийн ЕБС-ийн мэдээлэл технологийн танхим дахь компьютер, тоног төхөөрөмжийн хүртээмжийг нэмэгдүүлэн, боловсролын тэгш бус байдлыг бууруулах зорилго бүхий “Labdoo Ulaanbaatar Hub” 2024 төсөл Булган аймгийн Тэшиг сумын ЕБС-д 05-р сарын 11-ны өдөр амжилттай хэрэгжсэн.

Энэ удаагийн төслөөрөө бид тус сургуулийн мэдээлэл зүйн танхимыг 20 гаруй компьютер болон бусад дагалдах тоног төхөөрөмжүүдээр тохижуулан, сурагч дүү нартаа мэдээллийн технологийн ирэн үе, харилцаа, хандлагын талаар сургалт орон халуун дотно яриа өрнүүллээ.



ӨРГӨӨ РОТАРАКТ КЛУБ КЛУБ



Г. СУХБАТ

**Өргөө Ротаракт клубийн
Ерөнхийлөгч**

Гишүүд: 6

“Хүмүүн-Эрдэнэ” арга хэмжээ

“ХҮМҮН-ЭРДЭНЭ” Үндэсний өв соёлын энтертайнмент өдөрлөг 2024 оны 04 сарын 20-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Өдөрлөгөөр үндэсний өв соёл язгуур урлаг, ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтөний яаралтай хамгаалах жагсаалтад багтсан уран бичлэгийн үзүүлбэр, уран бичлэгийн дадлага, соёлын биет бус өвийн талаарх яриа, мэдээлэл, үндэсний бий биелэгээ зэрэг олон олон арга хэмжээ боллоо. Мөн “Орчин үе ба Үндэсний дархлаа” сэдэвт панел хэлэлцүүлэг өрнөлөө.



НАЙРАМДАЛ РОТАРАКТ КЛУБ КЛУБ



М. ЖАРГАЛМАА

**Найрамдал Ротаракт клубийн
Ерөнхийлөгч**

Гишүүд: 48

Halloween party

“Мөрөөдлийн булан” төслийн “Halloween Dream” хандивын арга хэмжээ 2023 оны 10-р сарын 28-ны өдөр бүх Ротарактуудын дунд зохион байгуулагдлаа. Уг арга хэмжээнд нийт 80 Ротаракт оролцож, төсөлд шаардлагатай хөрөнгийн 30%-ийг амжилттай цуглуулсан.



ЗАЛУУЧУУДЫН ӨРГӨН ЧӨЛӨӨ РОТАРАКТ КЛУБ КЛУБ



Б. МӨНХНАСАН

**Залуучуудын өргөн чөлөө
Ротаракт клубийн Ерөнхийлөгч**

Гишүүд: 41

Хэрэгжүүлсэн төсөл:

If I Knew

Тус төсөл нь бүтэн жилийн хугацаанд хэрэгжиж, төслийн судалгааны дагуу сонгосон хүүхдүүддээ хэд хэдэн сургалт болон үйл ажиллагаагаар, насанд хүрсэн хойноо их сургуульд хэрхэн суралцах, мэргэжлээ хэрхэн сонгох талаар зааварчилдаг төсөл юм.

Хамтарсан төслүүд:

Rotary club of Koga-East, Rotary club of Khuree-тэй хамтран Амгаланд байрлалтай Хүүхэд-Залуучуудын тусгай цогцолборт хувцас хандивлав.

**“Хүртээмжтэй боловсрол төсөл” болон
“Let’s Read” төсөл**

Аутизм ба онцгой хүүхдүүдийн академи-д англи болон монгол хэл дээрх номнууд хандивласан.



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛИЙН РОТАРАКТ КЛУБ



Д. ОЮУНЦЭЦЭГ

**Санхүү Эдийн Засгийн Их
Сургуулийн Ротаракт клубийн
Ерөнхийлөгч**

Хэрэгжүүлсэн төсөл:

Secret Santa төсөл

Санхүү Эдийн Засгийн Их сургуулийн хүрээнд шинэ жилийн баярыг тохиолдуулан SECRET SANTA төслийг санаачлан хэрэгжүүлсэн. Уг төсөл нь хүссэн хүндээ санта өвөөгөөр дамжуулан бэлэг хүргэлэн өгөх боломжтой. Клубын зүгээс бэлгийн багц гарган өөрсдийн хүссэн бэлгийн багцаа бий болгон нэрээ нууцалж болон нэрээ бичиж хүргүүлэх юм. Энэхүү төслөө 7 хоног хэрэгжүүлэн нийт 300000 гаруй төгрөгийн санхүүжилт бий болгож чадсан. Тус санхүүжилтээ БЯЦХАН БААТРУУД 2024 төсөлд бүрэн хандивласан.



ЦАСТ РОТАРАКТ КЛУБ КЛУБ



М. ЭНХСОЛОНГО

Цаст гүн Ротаракт клубийн Ерөнхийлөгч

Гишүүд: 30

Төслүүд

Kids room

Улаанбаатар Централ Ротари клубийн "Ger For Life" төслийн нэг хэсэг болж Хүүхдийн гэрийг 2022 оны зун тохижуулсан. Тус төслийн зорилго эрүүл зөв орчинд хүүхдүүд тоглох, сурч боловсрох, харилцаа, хандлагад эергээр нөлөөлөх, танин мэдэхүйн болон сэтгэхүйг хөгжүүлэхэд тохирсон ном тоглоомоор хангах халуун дулаан уур амьсгал бүрдүүлэх зорилготой. Энэ хүрээнд жил бүр хүүхдийн баяр үйл ажиллагаа зохион байгуулдаг, мөн хүүхдүүдэд сонирхолтой байх үүднээс Canvas day, Cupcake decoration зэрэг өдөрлөг хийж байсан.

Green House

"Ногоон хүлэмж" төсөл нь асрах төвийн хүүхдүүдийн хоол хүнснээсээ авч буй илчлэг, шим тэжээлийн хэмжээг нэмэгдүүлэх, зуны улиралд хүүхдүүдийг чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх боломжоор хангах, хүүхдүүдэд экологи, байгаль орчин болон хөдөө аж ахуйн салбарын талаар мэдлэг олгох, улмаар хөдөө аж ахуйн салбарыг сонирхож, ажиллах суурийг нь тавих зорилготой юм.



МАСУ сургалтын төвтэй хамтын ажиллагааны гэрээ байгууллаа.

2024 оны 1-р улирлаас эхлүүлэн "МАСУ" англи хэлний сургалтын төвтэй хамтын ажиллагаагаа эхлүүлсэн ба хамтын ажиллагааны хүрээнд 2 төрлийн санамж бичгийг байгууллаа. Өнөр бүл төв, Цаст Ротаракт клуб, МАСУ сургалтын төв нарын гурвалсан хамтын ажиллагааны хүрээнд Өнөр бүл хүүхдийн төвийн 5 хүүхэд МАСУ сургалтын төвийн 1 жилийн сургалтад үнэ төлбөргүй суралцаж эхэлсэн. Мөн МАСУ сургалтын төвд Цаст Ротаракт клубийн төсөл хөтөлбөрүүдэд санхүүжилт олох зорилготой хандивын ангийг нээхээр төлөвлөн ажиллаж байна.

Жижиг байшин

Улаанбаатар хотын амьдралд эзэнгүй амьтдын эзлэх байр суурь болоод нийгэмд амьтдын эрхийн талаар ойлголт өгөх зорилготой энэхүү төслийг манай клуб 2024 оны 4-р улирлаас эхлүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд төслийн хүрээнд эдгээр амьтдад зориулсан "Жижиг байшин" буюу үүрүүдийг хотын суурьшил ихтэй бүсүүдэд байрлуулах юм. Улаанбаатар хотын захиргаанаас эзэнгүй амьтдыг багасгах зорилготойгоор буудаж устгах арга нь орчин цагт тохирохгүй хэтэрхий харгис аргаас гадна ийм байдлаар эдгээр амьтдын тоо толгой буурах боломжгүй юм. Цаашид төслийн хүрээнд цуглах хандив, ивээн тэтгэлэг зэргээр бид амьтдын үржил хаах мэс засал буюу тоо толгойг багасгах хамгийн энэрэнгүй аргыг дэмжиж ажиллах болно.

Тогтмол зохион байгуулдаг үйл ажиллагаанууд

Coffee camping and Movie night

Ротари гэр бүлийн гишүүд болон кофе уух, агаарт кино үзэх дуртай хүн бүхэнд нээлттэй болдог Кофе кампинг болон Movie Night арга хэмжээнүүдийг жил бүрийн зун, намрын улирлуудад зохион байгуулсаар ирсэн бөгөөд цаашид ч илүү сайжруулан тогтмол зохион байгуулахаар төлөвлөж байна. Энэхүү арга хэмжээнүүдээр бид хэмжээнүүдээр бид зөвхөн клубийн төсөл хөтөлбөртөө санхүүжилт олохоос гадна Ротари гэр бүлийн гишүүдийг хоорондоо танилцах, хамтын ажиллагаагаа сайжруулах боломжоор хангах зорилготой ба кофены соёлын танилцуулга, киноны хэлэлцүүлэг, open mic үйл ажиллагаануудыг багтаасан байдгаараа онцлог юм.

Jeopardy Quiz night

2023 оны 4-р улирлаас эхлүүлэн манай клуб өөрсдийн нийгэмд чиглэсэн сайн дурын төсөл хөтөлбөрүүддээ санхүүжилт олох зорилготойгоор "Jeopardy by Tsast" арга хэмжээг зохион байгуулж эхлээд байна. 2 долоо хоног болгон зохион байгуулдаг тус арга хэмжээгээ бид хүн бүхэнд нээлттэй хэлбэрээр явуулдаг бөгөөд оюун ухаан, авхаалж самбаагаа сорин нэг оройг идэвхтэй өнгөрүүлэхдээ нийгэмдээ тус нэмэр болох боломжийг хүмүүст олгож байгаа юмаа.

УЛААНБААТАР СЕНТРАЛ РОТАРАКТ КЛУБ КЛУБ



А. ӨЛЗИЙТОГТОХ

**Залуучуудын өргөн чөлөө
Ротаракт клубийн Ерөнхийлөгч**

Гишүүд: 13

Little Heroes 2023

Бяцхан баатрууд төсөл нь хамгийн анх Туул Ротаракт клуб санаачлан хэрэгжүүлсэн төсөл бөгөөд 2018 оноос эхлэн бүх Ротаракт клубууд хамтран хэрэгжүүлж, 2023 оны байдлаар 6500 гаруй хүүхдүүдийг баярлуулаад байна. Энэ жил тус төслийг Улаанбаатар Сэнтрал Ротаракт клуб ерөнхий зохион байгуулагчаар сонгогдон 5000 ам.долларын санхүүжилт босгож, 300 гаруй хүүхдүүдийг баярлуулан, төслөө амжилттай зохион байгуулсан.



ХОББИ РОТАРАКТ КЛУБ



О. ТЭМҮҮЛЭН

**Хобби Ротаракт клубийн
Ерөнхийлөгч**

Гишүүд: 5

Хобби Ротаракт клуб нь өнгөрсөн жилүүдийн төсөл, хөтөлбөрүүдээ хэрэгжүүлж байгаа билээ.

ИХ ТЭНГЭР РОТАРАКТ КЛУБ



Э. ЛХАГВАСАЙХАН

**Их тэнгэр Ротаракт клубийн
Ерөнхийлөгч**

Гишүүд: 7

Их Тэнгэр Ротаракт клуб нь өнгөрсөн жилүүдийн төсөл, хөтөлбөрүүдээ хэрэгжүүлж байгаа билээ.

Rotaract
Clubs of Mongolia





ОЛОН УЛСЫН РОТАРИЙН 3450 ДҮҮРГИЙН 9,10-Р БҮСИЙН ИНТЕРАКТ КЛУБУУД



СЭЛБЭ ИНТЕРАКТ КЛУБ

Танилцуулга:

Манай Интеракт клуб нь 2021 онд Сэлбэ сургуулийн 2023 оны төгсөгч У.Номундарь-ийн удирдлага дор байгуулагдсан ба одоогоор 3 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Энэ жил манай клуб нийт 77 энгийн гишүүн, 11 board member элсүүлж авсан ба гишүүдийн тоо жил ирэх бүр өсөж байна.

Онцлох төсөл: “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв” -д хандив өргөх

2021 оноос хойш манай хамт олон жил бүр “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв”-д ном, тоглоом болон мөнгөн хандив цуглуулж өгсөн уламжлалтай. Энэ жил бид бүхэн эхэлснээс хойш хамгийн их хэмжээний буюу 200 гаруй ном, тоглоом болон 500,000 төгрөг хандивласан.



МОНГОЛ БИЛЭГ ОЮУ ИНТЕРАКТ КЛУБ

Клубын танилцуулга

Монгол Билэг Оюу Интеракт клуб нь 2022.04.16-нд албан ёсоор “Улаанбаатар Ротари клуб”-н охин клуб болж гэрчилгээгээ гардуулж авсан ба анх нийт 35 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа эхэлж байсан. Бидний уриа үг болох “BE WATER”. Маш их утга агуулсан ба энгийнээр ус шиг хүн болгонд хэрэгтэй, туслах гэсэн утгатай.

Үндсэн төсөл

Бид жил болгон “Movie day” гэх төсөл хийдэг. Тийм том төсөл биш ч гэсэн манай клубын гишүүдийн хамгийн хайртай төсөл. Уг төслөөр бид анги танхим, өрөөг тохижуулж 2- 12 дугаар ангийн хүүхдүүдийн насанд нь тохирсон киног үзүүлдэг. Жишээлбэл бага ангийн хүүхдүүдэд гадаад хэл сайжруулах тал дээр анхаарч англи хэл дээх хүүхэлдэйн кино үзүүлэх. Дунд ангийн хүүхдүүдэд хүмүүжил, төлөвшил дээр анхаарч сургамжтай кино үзүүлэх, харин ахлах ангийн хүүхдүүдэд Монгол кино үзүүлэх гэх мэт.



Хобби Сургуулийн Интеракт Клуб



INTERACT CLUB OF



HOBBY SCHOOL

Бидний тухай

Зорилго: Сургууль болон нийгэмд сайн сайхныг түгээх үйлсэд өөрийн гар биеэ дайчлан оролцох чин хүсэлтэй хүүхдүүдийг нэгэн уриан дор нэгтгэн хамтарч ажиллах

Байгуулагдсан он: 2012

Уриа: "Compassion to Action" - "Сэтгэлийн дэмээс сайн үйлсэд"

Хамрах хүрээ: Хобби ЕБС-ын 8-12р ангийн сурагчид манай клубын гишүүнээр элсэж мөн үйл ажиллагаанд хамрагдах эрхтэй билээ.

“Тусч Хобби” сайн үйлсийн аян

Гүйцэтгэгч: 2022-2023 оны болон 2023-2024 оны Интеракт клуб

Үйл ажиллагааны гол зорилго: Энэхүү сайн үйлсийн аян нь амьжиргааны түвшин доогуур, олон хүүхэдтэй айлд өргөө цагаан гэр хандивлах зорилгын доор явагдсан.

Үр дүн: “Тусч Хобби” сайн үйлсийн аяны үр дүнд амьжиргааны түвшин доогуур, таван хүүхэдтэй айлд өргөө цагаан гэр, хувцас, ном, тоглоом, хоол хүнс зэргийг хандивласан. Мөн үе тэнгийнхэн болон доод ангийн дүү нараа сайн үйлсийн аян хийхэд уриалж, зөв үлгэр дуурайлал болсон.



ШИНЭ МОНГОЛ ИНТЕРАКТ КЛУБ

Клубын танилцуулга

Шинэ Монгол Интеракт клубыг тус сургуулийн 11 дэх үеийн төгсөгч Ж.Намууны санаачилгаар 2013 онд байгуулсан бөгөөд өдгөө 2024 онд хүртэл нийгмийн сайн сайханд чиглэсэн олон төрлийн хүмүүнлэгийн сайн дурын ажлуудыг зохион байгуулж байна.

Энэ жил манай клуб нь нийт 63 гишүүдтэйгээр эхэлсэн. Бүгд нэгэнтэйгээ хамтарч, дотно уур амьсгалыг бүрдүүлсээр энэхүү хичээлийн жилийг дуусгаж чадсан. РОТАРИ клубээс зохион байгуулсан сагсны 3х3 тэмцээнд охидын баг 2-р байранд орж бидний амжилтыг нэгээр нэмж байсан.

“Together We Create Hope for a Better Environment” уриан дор Ротаричуудын зохион байгуулсан Эх дэлхийгээ цэвэрлэх өдөрлөгт манай клуб идэвхтэй нэгдлээ.

Бид Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулсан өдөрлөгийн үеэр Монголын Ротаричуудын тохижуулсан тоглоомын талбайг цэвэрлэж, тоглоомуудын өнгө будгийг сэргээхэд гар бие оролцсон.



ХҮРЭЭ КӨСЭН ИНТЕРАКТ КЛУБ

Клубын танилцуулга

Хүрээ Көсэнгийн Интеракт клуб. 2017 оноос хойш. Одоо 23 гишүүнтэй. Ээж клуб нь Хүрээ ротари.

Косплей арга хэмжээ

Бид дараагийн арга хэмжээний санхүүжилтийн төлөө косплэй тэмцээнийг зохион байгууллаа. Манай төсөв 200.000₮ байсан. Бид сургуулиа тохижуулж, арга хэмжээг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд манай клубын 23 гишүүн сайн дураараа оролцлоо.



ШИНЭ МОНГОЛ ХАРУМАФУЖИ ИНТЕРАКТ КЛУБ

Клубын танилцуулга

Манай клуб энэ жилийн 1 сард байгуулагдсан бөгөөд одоогоор 12 гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байгаа.

Бид одоогийн байдлаар 3 үйл ажиллагаанд хамрагдсан ба үүнд:

1. 3х3 олон улсын интерактуудын дунд зохион байгуулагдсан сагсан бөмбөгийн тэмцээнд амжилттай оролцов
2. Бидний оролцсон хоёр дахь үйл ажиллагаа бол Rotary Clean Day ба үүнд бид бусад Интеракт клубын гишүүдтэй оролцсон.



ЗУУН МОД ИНТЕРАКТ КЛУБ

Клубын танилцуулга

Манай Интеракт клуб нь 2023 онд Хүмүүн цогцолбор сургуулийн 2023 оны төгсөгч Н.Номин-гийн удирдлага дор байгуулагдсан ба одоогоор нийт 24 гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Бид одоогийн байдлаар 3 үйл ажиллагаанд хамрагдсан ба үүнд:

1. “END POLIO NOW” үйл ажиллагаанд клубын хамт олонтойгоо амжилттай оролцсон. Мөн интерактуудын дунд зохион байгуулсан тэмцээнд амжилттай оролцон шагналт байранд шалгарсан.
2. 2023.07.01-нд “Зуунмод Ротари” үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойн баярын өдөр “Зуунмод Интеракт” клуб маань албан ёсны сертификатаа гардан авсан.
3. 2024.03.11-нд зохион байгуулагдсан “Interact cup” 3*3 сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд 34 баг, 136 тамирчид оролцсон. Үүнд Зуунмод интеракт клубын хөвгүүдийн баг шилдэг 4 багт шалгарч, охидын баг Тэргүүн байр эзэлснээр Хонг Конг улсад зохион байгуулагдах “Гранд финал”-ын тоглолтод оролцох нэр хүндтэй үүргийг хүлээн авсан. Тэрхүү үүргээ сайн биелүүлж Аваргын цом алтан медалын эхэд болсон билээ.



ШИНЭ ҮЕ ИНТЕРАКТ КЛУБ

Онцлох төсөл:

“Хүүхэд бүр аз жаргалтай байх ёстой”

1. Зорилго: Сайн дурын төслийн ач холбогдлыг ойлгуулж, Хүүхдийн төвийг шинэ жилийн баяр баясгалангаар хангаж, тохижуулж, шаардлагатай зүйлсийг өгч, өдрийг хамтдаа аз жаргалтай өнгөрүүлэх.

Хүлээн авагчид: Зул сарын баяраар “Өнөр бүл” хүүхдийн төвийн 2 ангид 45 бэлэг өгч, тохижуулсан.

2. Зорилго: Жой буяны төвийн хүүхдүүдэд тусламжийн гараа сунгах. Өдрийг хамтдаа аз жаргалтай өнгөрүүлж, байгаль орчноо хайрлан хамгаалах, хайрлан хамгаалах үнэ цэнийг төлөвшүүлээрэй.

Хүлээн авагчид: Цагаандаваагийн хогийн цэг орчимд амьдардаг +20 хүүхэд гэр бүлийн хамт.



НИЙСЛЭЛ ИНТЕРАКТ КЛУБ

Клубын танилцуулга

Нийслэл интеракт клуб нь “Let’s Study Abroad” уриан дор 2022.08.13 нд ирээдүйд дэлхийн топ их сургуулиудад суралцах хүсэлтэй 12-18 насныхны нэгдлээр Монголын анхны “Community-based” Интеракт клуб болон үүсгэн байгуулагдсан юм. Үүсгэн байгуулагдсанаас хойш 2 жилийн хугацаанд клубийн гишүүд маань гадаадад суралцах талаар бусдад болон өөрсдөдөө тогтмол мэдлэг мэдээллийг түгээж туслалцаа үзүүлэхээс гадна хүүхдүүд рүү чиглэсэн сайн дурын төслүүдийг хэрэгжүүлсээр ирлээ. Сүүлийн нэг жилийн хугацаанд клубийн хурал болгон дээр гишүүддээ зориулан АНУ ийн их сургуулиудын өргөдлийн системд хамтдаа бэлдэх зорилготой семинар хичээлүүдийг бэлтгэн хүргэсэн. “Манна нялхсын асран хамгаалах төв” дээр тогтмол сард 2 удаа хүүхдүүдтэй нэг өдрийг хамт өнгөрүүлэнгээ зарим нэг ажилд тус болох зорилготой “Lead the Path” төслөө энэ жил эхэлснээс хойш хэрэгжүүлж байна. Мөн “Velloo Foundation”-ний байгуулсан нийтийн номын сан болох “Gandys Kids Campus Community Library”-д хэрэгжүүлж эхлээд буй төслөө Онцлох төсөл болгон танилцуулж байна.

Бид долоо хоног бүр **“Gandys Kids Campus Community Library”** номын санд “Сонирхолтой хагассайн” төслөө хэрэгжүүлэн явуулж байгаа билээ. Хүүхдүүд өөрсдийн мэддэггүй танил бус зүйлсээ ухаж судалж үздэггүй учраас бид энэхүү төслөөрөө хүүхдүүдэд сонирхолтой спорт, гар урлалын төрлүүдээс танилцуулж, өөрсдөөр нь хийлгүүлж түүнийгээ дараа нь өөрсдөө дахин нарийн сонирхож судлах мэдэх, цаашдаад өөрсдийн шинэ сонирхол мөрөөдлийг олоход нь дэмжлэг болох зорилгоор долоо хоног болгон номын сангийн уншигч хүүхдүүдтэй цагийг өнгөрөөж байна.



АБСОЛЮТ ЭЛИТ ИНТЕРАКТ КЛУБ

Байгуулагдсан жил: 2021 он

Ээж клуб: Сэлбэ ротари клуб

Гишүүдийн тоо: +80

Төсөл: IELTS-д орох боломж

Зорилго: IELTS-ийн шалгалтын төлбөрийг төлөх боломжгүй оюутнуудыг дэмжих

Үр шим хүртэгчид: санхүүгийн бэрхшээлтэй оюутнуудад чиглүүлснээр энэ нь урамшуулах болно. Оюутнуудыг англи хэл сурах, сургууль, тэтгэлэгт хамрагдах хүсэл эрмэлзлийг төрүүлдэг, хилийн чанадад, улмаар Монголд боловсон хүчин бэлтгэхэд хувь нэмрээ оруулна.

Хүлээгдэж буй үр дүн: дор хаяж 10 оюутанд туслах



23-Р СУРГУУЛИЙН ИНТЕРАКТ КЛУБ

Клубын танилцуулга

Манай клуб 2021 оны 3-р сарын 23-нд үүсгэн байгуулагдаж, 2021 оны 11-р сарын 27-нд албан ёсоор Interact клубын гэрчилгээгээ авсан. Байгуулагдаад 4 дэх жилтэйгээ золгож байна. Одоогоор ахлах, дунд ангийн нийт 48 сурагч 4 хорооны тэргүүлэгч гишүүдтэй хамтран ажиллаж байна.

Бидэнд клуб болон ажиллахад хамгийн их нөлөөлж, тусалдаг зүйл бол “Хэлэлцүүлэг” юм. Сувдан зүүлтний тархай бутархай сувдны түүхтэй адил чанартай зүйлийг бие биетэйгээ ярилцан бүтээж чадаж байгаа нь бидний хамгийн том тулгуур давуу тал юм.

Үндсэн төсөл: “Шаахайтай өдөр”

Энэхүү төсөл нь сургуулийн орчны цэвэрлэгээнд зарцуулдаг усны хэмжээг багасгах, үйлчилгээний ажилчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх зорилготой юм. Багш сурагчид 7 хоног сургуулийн дотуур шаахай өмсөнө. Төсөлд 1800 орчим оюутан, 60 багш оролцсон.



НАРАН ИНТЕРАКТ КЛУБ

Клубын танилцуулга

Наран Интеракт клуб нь Наран Ерөнхий Боловсролын сургуулийн төгсөгч Э.Буяндарийн санаачилгаар үүсгэн байгуулагдаж байсан бол өдгөө нийт 36 гишүүдтэй идэвхтэй үйл ажиллагаагаа явуулж байгаа ба 2023-2024 оны ротари жилд клубийн ерөнхийлөгчөөр М.Мятав сонгогдон ажиллаж байна.

2018 оноос хойш Нарлаг Улаанбаатар Ротари Клуб нь бидний ээж клуб болж албан ёсны туг, сертификатаа хүлээж авсан билээ. Мөн дээрээс нь манай клуб Төслийн хороо, Олон нийттэй харилцах хороо, Ногоон хороо гэх гурван хороодод хуваагдан ажилладаг.

Энэ Ротари жил (2023-2024) бид, тогтвортой хөгжлийн 3-р зорилт болох эрүүл мэндийг дэмжих зорилтын хүрээнд, Нарлаг Улаанбаатар Ротари клубтэй хамтран сургуулийн анги бүрд гар хийцийн эко даавуун уут бүхий анхны тусламжийн хэрэгслийн багцыг хандивлах төслийг амжилттай хэрэгжүүллээ. Энэхүү төсөл нь эрс тэрс уур амьсгалтай оронд гэнэтийн санамсаргүй байдлаар сургуулийн орчинд сурагчдыг гэмтэж бэртэх, нөхцөл байдлыг илүү хүндрэхээс сэргийлээд зогсохгүй сургуулийн орчинд эмчийн хүрэлцээгүй үеүүдэд анхны тусламж үзүүлэх боломжийг илүү бий болгосон гэдгээрээ онцлог.

Энэхүү төслийг хэрэгжүүлэхийн тулд сургуулийн багш, ажилчид, сурагчид гэх мэт хүмүүс анхны тусламжийн сургалтад хамрагдсан. Ингэснээр яаралтай үед тусламжийг цаг алдалгүй сургуулийн орчинд хаана ч, хэзээ ч авах боломжтой болсноороо давуу талтай. Мөн бид энэ төслийг сурагчдын сургууль дээрх гэмтэл бэртийн судалгааг авч үзэн тэдний суралцах орчны аюулгүй байдлыг хангах ёстой гэсэн санааг баримталсан бөгөөд дараагийн шаардлагатай сургуульд хэрэгжүүлэхээр судалж, хоёр дахь удаагаа хэрэгжүүлэхээр ажиллаж байна.



Interact
Clubs of Mongolia



АШУУИС ЛИЦЕЙ ИНТЕРАКТ КЛУБ

2024 оны 2 сарын 24 нд “Нарлаг Улаанбаатар” Ротари клубын дэргэд “АШУУИС ЛИЦЕЙ интеракт клуб”-ыг байгуулж, “Өөрөөсөө давж бусдад туслая” уриан дор сайн дурын үйл ажиллагаа явуулах, оролцох эрхтэй болсон. Нийт 55 гишүүн Г.Оюунбилэг, М.Саранцэцэг чиглүүлэгч багш нартай боловсролын хөгжилд хувь нэмрээ оруулж, байгаль орчноо хамгаалж, аутизмын хүрээний эмгэгийн талаарх ойлголтын нэмэгдүүлэн, манлайллын чадавхиа хөгжүүлэн найз нөхөд боллоо. Монголын интеракт клубууд дунд зохион байгуулагдсан анхны “Interact Mongolia” 3X3 сагсан бөмбөгийн тэмцээнд нийт 17 сургуулийн 33 багийн 132 тамирчид оролцсоноос манай хөвгүүдийн баг 4-р байр, охидын баг 3-р байрт шалгарч Хүрэл медаль хүртсэн билээ. Түүнчлэн бид Франц хэлний баярын сагсан бөмбөгийн тэмцээнд оролцож, “Teen Teacher” хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж, “Let’s read Mongolia”, “Rotary Clean day”, “Kids Art Festival” үйл ажиллагаануудад идэвхтэй хамрагдсан.

Бидний анхны төсөл “Гайхамшигт ертөө”

Аутизм нь хүний бусадтай харилцах, нийгмийн харилцаанд орох, мэдээллийг хүлээж авч ойлгох чадварт нөлөөлдөг өргөн хүрээний эмгэг юм. Монгол улсад аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдүүдийг сургах ажлыг сэргээн засах төвүүд, цөөхөн сургууль, зарим нэг төрийн бус байгууллагуудад тодорхой хугацаанд ганцаарчилсан болон тусгай боловсролын үйлчилгээг явуулж байна. Үүний нэг нь “Гайхамшигт ертөнц” цогц хөгжлийн төв юм. Бид тус төвийн “Ego therapy” (sensory room) буюу сэргээн заслын өрөөнд засвар, тохжилт хийхээр зорьж энэхүү төслийг эхлүүлсэн билээ. Аутизмтай хүүхдүүдэд зориулсан мэдрэхүйн өрөө нь хүүхдийн стрессийг тайлж, тайвшруулах нөлөө үзүүлдэг мэдрэхүйд ээлтэй объектуудыг агуулсан аюулгүй өрөө юм.



ШИНЭ ЭХЛЭЛ ИНТЕРАКТ КЛУБ

“Шинэ эхлэл интеракт клуб” нь залуучуудын дунд олон нийтийн үйлчилгээг дэмжих, манлайлал болон олон улсын ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн, идэвхтэй сайн дурын байгууллага юм. Манай клуб нь дэлхийн Interact Club сүлжээний нэг хэсэг бөгөөд залуучуудыг төрөл бүрийн төслүүд, багийн ажиллагаа болон хувийн хөгжилд оролцуулах замаар эерэг нөлөө үзүүлэхэд тусалдаг. Орон нутгийн болон дэлхийн санаачилга дээр төвлөрсөн тус клуб нь өгөөмөр сэтгэл, хамтын ажиллагааг дэмжиж, гишүүдийг хариуцлагатай, оролцоо ихтэй иргэд болоход бэлтгэдэг.

Манай клубын олон сайн дурын ажлын нэгээс хүргэхэд, ‘Нарлаг УБ’ ээж клубээсээ санхүүжилт босгон, 2162000 төгрөгийн үнэ бүхий хүүхдийн бүтээлч сэтгэлгээг дэмжих тоглоом ба бага насны хүүхдүүдэд зориулсан танин мэдэхүй болон үлгэрийн 91 номыг “Шинэ эхлэл” сургуулийн сурагч нараасаа хандивлуулж, “Хүүхдийн төв сувилалд” хандивласан билээ.



УЛААНБААТАР АНГЛИ СУРГУУЛЬ ИНТЕРАКТ КЛУБ

Клубын танилцуулга

Манай клубын хүч чадал нь эерэг нөлөө үзүүлэх чин хүсэлтэй гишүүддээ оршдог. Бид утга учиртай үйл хэрэгт хувь нэмрээ оруулах чадвараа дээд зэргээр нэмэгдүүлж, үр дүнтэй хамтран ажилладаг, дэмжигч олон нийтийг дэмжинэ. Түүнчлэн манай байгууллагын бүтэц нь гол хүч юм. Бид шинээр гарч ирж буй хэрэгцээ шаардлагад нэн даруй хариу өгөх боломжийг олгодог тодорхой харилцааны суваг, үр ашигтай зохицуулалтын механизмыг бий болгосон. Энэ нь бидний хүчин чармайлт үр дүнтэй бөгөөд бидний үндсэн зорилгод нийцэж байгааг баталгаажуулдаг.

Гол төсөл: Гутлын хайрцаг, Бага ангийн сурагчидтай унших хичээл.

Зорилго/ Тайлбар: Бид талх нарийн боовны борлуулалтаас олсон ашгаа тоглоом, хувцас худалдаж авахад зарцуулсан. Цаашилбал, бид сургууль, хамт олныхоо оюутнууд, гишүүдээс илүү их хандив цуглуулсан. Эцэст нь бид тусламж хэрэгтэй хүүхдүүдэд сайхан боосон гутлын хайрцгийг бэлэглэв. Бяцхан хүүхдүүдэд ном уншиж, тэдэнтэй ярилцах нь тэдэнд сургууль дээрээ асуудалтай тулгарвал тэдэнд чөлөөтэй ярих асуулт асуух боломжийг олгоно гэж бид найдаж байсан.



115-Р СУРГУУЛИЙН ИНТЕРАКТ КЛУБ

Байгуулагдсан жил: 2022 оны 12-р сарын 10

Ээж клуб: Гэрэгэ Ротари

Гишүүдийн тоо: 75

Төсөл: "Бүх амьтан аз жаргалтай байх болтугай"

Зорилго: Зорилго нь муур, нохойг хайрлаж сурах, амьтдын хашаа хороо ямар байдгийг харах, тэдэнд ямар асуудал тулгардагийг мэдэх явдал юм. Үр дүн: "Хөөрхөн зулзага ТББ"-д очиж нэг өдрийг нохой, мууртай өнгөрүүллээ. Бид олсон 250 мянган төгрөгөөр нохой, муурны хоол авсан. Мөн амьтны байр ажиллуулахад хичнээн их цаг хугацаа, хүч хөдөлмөр зарцуулдгийг мэдэж авлаа.



МОНГОЛ - АВСТРАЛИЙН ХАМТАРСАН СУРГУУЛИЙН ИНТЕРАКТ КЛУБ

Клубын танилцуулга

Манай клуб 2024 онд байгуулагдсан бөгөөд нийт 65 гишүүнтэй ба 14 удирдах албаны гишүүнтэй. Түүнчлэн манай клубын спонсор клубууд нь "Tsetsee Cung Rotaract" болон "Ulaanbaatar Rotary" юм. Энэ нь Монголд анх удаа ротари, ротаракт хамтдаа нэг интеракт клубыг спонсорлож байгаа тохиолдол юм.

Оролцсон үйл ажиллагаа, төслүүд

Улаан Чулуут орчмын дэмжих бүлгийн хүүхдүүдэд туслах аян

Бид анх 6/2-нд Улаан чулуутын нөхцөл байдалтай танилцаж, 3/29-нд сургуулийн гар бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн дээр "Bake day" зарлан олсон хандиваас цугларсан мөнгөөрөө хүүхдийн баярыг тохиолдуулан Улаан чулуутын хүүхдүүдэд туслах аян зохиож 3 өдрийн турш сургуулийн багш, сурагч нараас хуучин тоглоом, хувцас гэх мэт бусад зүйлсийг цуглуулан 6/8-ний өдөр Харилцааны хөгжил төв ТББ дээр очин цугласан бүх мөнгөөрөө Улаан чулуут орчмын дэмжих бүлгийн айл өрхийн 150 гаруй хүүхдүүдийг хооллож, тоглож хамтдаа нэг өдрийг үр дүнтэй өнгөрөөлөө. Бид цаашлаад Харилцааны хөгжил төв ТББ-гийн Улаан Чулуутын хүүхдүүдийн сурч буй сургуульд туслалцаа үзүүлхээр төлөвлөж байна.



ӨРГӨӨ ИНТЕРАКТ КЛУБ

Клубын танилцуулга

Байгуулагдсан жил: 2022 он

Ээж клуб: Их Өргөө Ротари клуб

Гишүүдийн тоо: 26

Төслийн нэр: Номын Өргөө

Зорилго: Төв аймгийн Аргалант суманд байрлах сургуулийн дотуур байрны номын булан байгуулж, сурагчдын сэтгэх чадварыг хөгжүүлэн зорилгодоо хүрэхэд туслах.

Давуу тал: Хүүхдүүд номын санд бус сурахад маш тухтай орчинд уншиж мэдлэгээ тэлнэ.

Бид саяхан төслийн хөрөнгөө босгож номоо хандиваар цуглуулж дуусаад бөгөөд хичээлийн шинэ жил эхлэхээс өмнө энэ зундаа багтаан Төв аймгийн сургуульд номын булангаа байгуулах болно



UNG-ИЙН ИНТЕРАКТ КЛУБ

Байгуулагдсан жил: 2020 оны 2-р сарын 2

Ээж клуб: “Нийслэл” Ротари клуб

Манай үйл ажиллагаа

1. 38-р сургууль 12-р сарын 1-ний өдөр ДОХ буюу Дархлалын олдмол хомсдолын талаар сурагчдад дэлгэц, самбараар дамжуулан мэдээлэл өгөхөөс авахуулаад 15 гаруй үйл ажиллагаа.
2. Жил болгон 2 удаа хүүхдүүдэд бэлэг тараав(Шинэ жил, Эх үрсийн баярыг тохиолдуулан)
3. 2022 оны 11 сарын 25нд 38-р сургуулийн сурагчдад мэргэжил сонголтын талаар сургалт зохион байгуулав.
4. 2023 оны 5 сарын 20нд 25-р эмийн сангын ойролцоох эргэн тойронг цэвэрлэв.



ТОМЪЁО ИНТЕРАКТ КЛУБ

Томъёо Интеракт Клуб нь 2024 оны 2-р сарын 24-нд Улаанбаатар Скай клубын дэмжлэгтэйгээр үүсгэн байгуулагдсан ба Томъё Олон Улсын Сургуулийн 90 гаруй сурагчдийн дунд Эссэ бичлэгийн уралдаан зарлаж үүнээс 22 шилдэг сурагчийг гишүүнээр элсүүлсэн. ЕБС-ийн сургуулийн дүү нартаа англи хэл заах төслийг анхны төслөөрөө сонгож хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.



Interact
Clubs of Mongolia



ДАРХАН ЮНИТИ АВЕНЬЮ ИНТЕРАКТ КЛУБ

Клубын танилцуулга

Дархан Юнити Авенью Интеракт клуб нь олон нийтэд суурилсан клуб ба анх хуучин Японы Интеракт клубын гишүүн Э. Өгөдэйгийн санаачлагаар 2023 онд үүсгэн байгуулагджээ. Манай Интеракт клуб нь тогтвортой хөгжлийн зорилтын 4-р зорилт буюу Чанартай Боловсролыг дэмжиж үйл ажиллагаагаа явуулдаг. Бидний зорилго нь олон улсын ойлголтыг нэмэгдүүлэх болон боловсролыг нээлттэй олгох явдал юм.

“ЦААС ДАХИН БОЛОВСРУУЛАХ” ТӨСӨЛ

Уг төслийн хүрээнд Оюуны Ирээдүй сургуульд цаас дахин боловсруулалтын талаар сонирхолтой мэдээлэл бүхий постер тараасан ба дунд ангийн сурагчдад 7 хоногийн хугацаатай арга хэмжээг 2024 оны 2 сарын эхээр зохион байгуулсан. Арга хэмжээнд цаас болон цаас дахин боловсруулалтын талаар мэдээлэл өгсөн бөгөөд цаас дахин боловсруулах туршилт хийсэн. Үүний дараагаар 2024 оны 6 сарын 10-нд дахин боловсруулсан бүтээгдэхүүнээр бүтээл хийх “Naturelympics” уралдаанд оролцож 1-р байрыг эзлэв.

НАНИВА БОЛОН ДЮА ИНТЕРАКТ КЛУБУУДЫН ЦАХИМ УУЛЗАЛТ

2024 оны 5 сарын 25-ны өдөр Японы Нанива Интеракт клубтэй танилцах цахим уулзалтыг зохион байгууллаа. Уг уулзалтаар бид улс орныхоо соёлын талаарх мэдээллүүдийг солилцсон ба олон улсын ойлголтыг дээшлүүлсэн уулзалт болсон юм. Бид мөн уулзалтын төгсгөлд хамтын ажиллагаа болон ирээдүйн төслүүдийн талаар ярилцлаа.

ОЛОН УЛСЫН ЗӨГИЙНИЙ ӨДРИЙН АРГА ХЭМЖЭЭ

Олон улсын Зөгийний өдрийг тохиолдуулан манай клуб нь Дарханы Американ Корнертой хамтран Дарханчуудад зөгийний талаар болон аж ахуйн талаар сонирхолтой байдлаар нэг өдрийн арга хэмжээг зохион байгуулав.



“АЗИ НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН РОТАРАКТУУДЫН ЧУУЛГА 2025 МОНГОЛД

Бид албан ёсоор “Ази Номхон Далайн Бүсийн Ротарактуудын Чуулга 2025 /Asia Pacific Regional Rotaract Conference/ буюу APRRC арга хэмжээг 2025 оны 6 сарын 6 – 9 хооронд Монгол улсад зохион байгуулах эрхийг авлаа. Энэхүү ажлын бэлтгэл ажил явуулж дэмжлэг туслалцаа үзүүлсэн бүгдэнд нь талархал эрэлхийлж зохион байгуулах коммист амжилт хүсэе.



Rotary
District 3450



Rotary
Clubs of Mongolia



Rotaract
Clubs of Mongolia





2024-2025 оны Ротарийн жилд 9,10-р Бүсийн Захирагчаар ажиллахаар сонгогдсон Б. Долгурсүрэн болон Б. Жавхлан нартаа, тэдний удирдлагын багт их амжилтыг хүсч, дахин нэг гайхалтай жилийг хамтдаа бүтээцгээе.



DAGE сонгууль анх удаа зохион байгуулж 3 үеийн Бүсийн захирагч нар нэг баг болж ажиллаж байна.

2023-24 Бүсийн Захирагч нар Б. Сальма болон Б. Номуунбилэгт

2024-25 Бүсийн Захирагч нар Б. Долгурсүрэн болон Б. Жавхлан

2025-26 Бүсийн Захирагч нар А. Дашдулам болон С. Намжилмаа





“Serve Above Self”

Өөрөөсөө давж бусдад тусалъя уриатай,
сайхан сэтгэлт Ротари гэр бүлийн Итгэл найдварыг
Дэлхийд авчирсан жил